МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН

ГАРЫН АВЛАГА

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН ГАРЫН АВЛАГА

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН

ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар 2024

Сэтгүүлчдэд зориулсан эдийн засгийн гарын авлага

Хоёр дахь хэвлэл

Хянан тохиолдуулсан: "Мөнгө, санхүү, баялаг" сэтгүүлийн эрхлэгч, доктор, профессор Б.Болдбаатар (D.Sc.)

Боловсруулж, хянасан: Олон нийтийн санхүүгийн боловсролын төв: Н.Батжин, Э.Хүслэн, Г.Ананд, Б. Хулан, Д.Намуун, Б.Номун

ӨМНӨТГӨЛ

Эдийн засгийн орчинд мэдээллийн тэгш бус байдал, бодлого боловсруулалтыг ойлгомжтойгоор түгээх шаардлага улам бүр нэмэгдэж байгаа энэ үед эдийн засгийн сэтгүүлчдийн үүрэг, хариуцлага чухал билээ. Төв банкны зүгээс эдийн засгийн мэдээлэл, арга хэрэгслийг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой хүргэхийн тулд сэтгүүлчдийн мэдлэг боловсролд хувь нэмэр оруулахыг зорьж ирсэн ба сургалтын материалд багтсан агуулгыг нэгтгэн энэхүү гарын авлагыг Та бүхний анхааралд толилуулж байна.

Сэтгүүлчдийн ажил нь зөвхөн мэдээлэл дамжуулахаас гадна, зах зээлийн оролцогчдод бодлогын ач холбогдлыг ойлгуулах, олон нийтийн саналыг бодитой баримтад тулгуурлан төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд үүгээр дамжуулан эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжих боломжтой юм.

Тус гарын авлагыг хоёр дахь хэвлэлтэд бэлтгэхдээ эдийн засгийн суурь ойлголт, Төв банкны үйл ажиллагааны чиг үүргийг гүнзгийрүүлэн таниулахын тулд анхны хэвлэлийн агуулгыг илүү өргөн хүрээнд боловсруулж, эмхэтгэлээ.

ГАРЧИГ

Өмнөтгөл 3

Товчилсон үгсийн жагсаалт 5

Мөнгөний ба төсвийн бодлого 7

Мөнгөний бодлогын хэрэгслүүд ба
мөнгөний зах зээл дээрх үйл ажиллагаа 19

Инфляц 29

Зээлийн тухай ойлголт 41

Эдийн засгийн мөчлөг 51

Валютын ханш 57

Төлбөрийн тэнцэл 67

Монголбанкны статистикийг хэрхэн ашиглах вэ? 71

Санхүүгийн тогтвортой байдал ба макро зохистой бодлого 83

Монгол Улсын төлбөрийн систем 91

Ногоон эдийн засаг 95

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
БХЗ	Банк хоорондын зах
МЗБХ	Макро зохистой бодлогын хэрэгслүүд
ОУВС	Олон улсын валютын сан
СТБЗ	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл
ТБҮЦ	Төв банкны үнэт цаас
ӨОХ	Өр, орлогын харьцаа
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЭУА	Эрсдэлийн удирдлагын алба

СЭДЭВ

01

МӨНГӨНИЙ БА ТӨСВИЙН БОДЛОГО

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТӨРӨЛ

Эдийн засгийн бодлогыг хамрах хүрээгээр нь дараах байдлаар ангилах боломжтой.

1. Макро эдийн засгийн бодлого:

- Мөнгөний бодлого;
- Төсвийн бодлого;
- Валютын ханшийн бодлого.

Макро эдийн засгийн бодлого нь улс орны эдийн засгийн голлох үзүүлэлтийг удирдах замаар эдийн засгийн тогтвортой өсөлт, үнийн тогтвортой байдал, бүрэн ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдал зэргийг хангахад чиглэнэ. Улмаар эдийн засаг дахь нийт эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлж, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг бүрдүүлэхийг зорьдог. Гадаад тэнцвэр гэдэг нь төлбөрийн тэнцэл буюу урсгал данс болон хөрөнгийн дансны тэнцвэрт байдлыг хэлнэ. Харин дотоод тэнцвэр гэдэг нь эдийн засаг бүрэн ажил эрхлэлттэй, инфляц тогтвортой байх үеийн үйлдвэрлэл буюу потенциал үйлдвэрлэлийн түвшнийг хэлнэ.

Макро эдийн засгийн бодлого ба нийт эрэлт, нийлүүлэлтийн муруй



Эх сурвалж: Principles of Macroeconomics (N. Gregory Mankiw, 2013)

2. Микро эдийн засгийн бодлого:

- Аж үйлдвэрийн бодлого;
- Зохистой бодлого;
- Байгаль орчны бодлого.

Микро эдийн засгийн бодлого нь айл өрх, компани, хэрэглэгчид гэх мэт эдийн засгийн агентын зан төлөв, шийдвэр гаргалтад нөлөөлөх замаар нөөцийн хуваарилалт, зах зээлийн үр ашиг, халамжийн хүртээмж зэргийг сайжруулахад чиглэнэ.

ТӨСВИЙН БОЛОН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН УЯЛДАА

Мөнгөний бодлого нь 1980 он хүртэл төсвийн бодлогын хавсарга байдалтай явж ирсэн. Түүнээс хойш тодорхой дүрэмд суурилсан төсвийн бодлого болон инфляцын онилох бие даасан мөнгөний бодлогыг хөгжингүй орнууд тусад нь хэрэгжүүлж эхэлсэн байна. Төсөв, мөнгөний бодлогын уялдаа нь тухайн орны банк, санхүүгийн салбарын гүнзгийрэлт, ханшийн дэглэм, институтийн бүтэц зэрэг онцлог шинжээс хамаардаг. Төсвийн бодлого нь урт хугацааны тогтвортой байдалд чиглэх ёстой бөгөөд мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд макро эдийн засгийн болоод санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг.

Төсвийн болон мөнгөний бодлогын уялдаа болон ялгаа



Эх сурвалж: Монголбанк

МӨНГӨНИЙ БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?

Төв банк нь мөнгөний нийлүүлэлт зэрэг хэрэгслээр дамжуулж эдийн засгийн өсөлт, бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, төлбөрийн тэнцэл, ажилгүйдэл гэх мэт макро эдийн засгийн орчинд нөлөөлөх үйл ажиллагааг мөнгөний бодлого гэнэ. Мөнгөний бодлого нь улс орны эдийн засгийн хөгжлийг удирдах макро эдийн засгийн бодлогын нэг хэсэг бөгөөд Засгийн газраас хараат бус байж, зах зээлийн механизмд суурилан хэрэгждэг онцлогтой.

ТӨВ БАНКНЫ ҮНДСЭН ЗОРИЛГО

Улс орнуудын төв банкны дийлэнх нь үнийн тогтвортой байдлыг хангахыг үндсэн зорилтоо болгодог. Мөн энэ зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны салбарын тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлдэг.

Төв банк нь мөнгөний бодлогыг холбогдох хэрэгслүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг ба ингэхдээ инфляцын тодорхой зорилтыг дэвшүүлж, үнийн тогтвортой байдлыг хангадаг. Өөрөөр хэлбэл, үнийн тогтвортой байдал нь инфляц Төв банкны зорилтот түвшинд байхыг хэлнэ. Монгол Улсын хувьд энэ нь 2024 оны байдлаар 6%±2% интервал буюу энгийнээр бол 4-өөс 8 хувийн хооронд байна.

Инфляцын зорилт



Эх сурвалж: Монголбанк

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТЭД НӨЛӨӨЛӨХ БОДЛОГО

Төв банк нь мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөхдөө хуулиар зөвшөөрөгдсөн арга хэрэгслүүдийг ашигладаг.

Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь төрөөс баримталж байгаа мөнгөний бодлогын талаарх үндсэн чиглэл буюу түүний зорилгоос хамаардаг. Үүнтэй холбоотойгоор Төв банк нь мөнгөний ХАТУУ болон ЗӨӨЛӨН бодлогын аль нэгийг сонгон хэрэгжүүлдэг байна. Мөнгөний нийлүүлэлтэд мөнгөний бодлогоос гадна Засгийн газраас хэрэгжүүлдэг төсвийн бодлого нөлөөлдөг учраас төсвийн бодлогын цаашдын чиг хандлагыг харгалзан үзэж, Төв банк бодлогоо тодорхойлдог.

Мөнгөний болон төсвийн бодлогын нөлөөлөл



Эх сурвалж: Монголбанк

МӨНГӨНИЙ ХАТУУ, ЗӨӨЛӨН БОДЛОГО

Мөнгөний зөөлөн бодлого:

Эдийн засгийн уналтын үед ажилгүйдлийг бууруулж, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор мөнгөний нийлүүлэлтийг өсгөж, мөнгөний зөөлөн бодлогыг хэрэгжүүлдэг байна. (Жишээлбэл, бодлогын хүүг бууруулах)

Мөнгөний зөөлөн бодлого буюу бодлогын хүү буурах

Эх сурвалж: Зохиогчид

Мөнгөний хатуу бодлого:

Эдийн засгийн мөчлөгийн сэргэлтийн болон оргил үед үнийн ерөнхий түвшний өсөлтийг бууруулах, урьдчилан сэргийлэх, мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зорилгоор мөнгөний хатуу бодлогыг авч хэрэгжүүлдэг ажээ (Жишээлбэл, бодлогын хүүг өсгөх)

Мөнгөний хатуу бодлого буюу бодлогын хүү өсөх

Эх сурвалж: Зохиогчид

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТОД ХҮРЭХ НЬ

Мөнгөний бодлогын үйл ажиллагаа нь мөнгөний бодлогын шилжих механизмаар дамжин эцсийн зорилгодоо хүрч хэрэгждэг. Мөнгөний бодлогын өөрчлөлт нь бодит эдийн засаг буюу энгийн иргэдийн

амьдралд тодорхой хоцрогдолтой нөлөөлдөг ба ингэхдээ хэд хэдэн сувгаар дамжин бодлогын эцсийн зорилгод нөлөөлж байгааг шилжих механизмаар тайлбарладаг.

Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлогын хэрэгсэлд гарсан өөрчлөлт нь үнэт цаас, зээл, хадгаламж зэрэг мөнгөний захын хүүний түвшнийг өөрчилж, улмаар иргэдийн зүгээс эдийн засгийн хэтийн төлөвийн талаарх хүлээлт, хөрөнгийн үнэ, валютын ханш зэргээр дамжиж, хувь хүн болон компанийн зардал, хадгаламж болон хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлдөг.

Мөнгөний бодлогын дамжих суваг



Эх сурвалж: Зохиогчид

ТӨСВИЙН БОДЛОГО ГЭЖ ЮУ ВЭ?

Төсвийн бодлого гэдэг нь Засгийн газрын зардал болон орлогоор дамжуулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, инфляцыг тогтворжуулах, ажилгүйдлийг бууруулах зэрэг эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн үйл ажиллагаа юм.

Төсвийн бодлого эдийн засагт нөлөөлөх нь



Эх сурвалж: Монголбанк

ТӨСВИЙН БОДЛОГЫН АНГИЛАЛ

Төсвийн бодлогыг зорилтот ба зорилтот бус гэж хоёр ангилж үздэг.

Зорилтот төсвийн бодлого (дискрет): Засгийн газраас урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, инфляцыг тогтворжуулах, ажлын байр бий болгох зорилгоор нийт эрэлт буюу төлөвлөгдсөн зардалд сангийн бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан зориудаар нөлөөлж байгаа хэлбэр юм. Дискрет төсвийн бодлогыг Сангийн тэлэх бодлого, Сангийн хумих бодлого гэж хоёр ангилна.

Зорилтот бус төсвийн бодлого (дискрет бус): Засгийн газраас тухайн хугацаанд зориудаар нийт эрэлтэд нөлөөлөх бодлогын арга хэмжээ хэрэгжүүлээгүй байхад эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс үүдэн сангийн бодлогын хэрэгслүүдэд өөрчлөлт гарахыг хэлнэ. Жишээлбэл, эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгаа үед *шаталсан татвар* нь орлогыг нэмэгдүүлэх, *ажилгүйдлийн тэтгэмж* нь зардлыг бууруулах нөлөөтэй.

ТӨСВИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

- **Засгийн газрын зардал:** Засгийн газар нь эдийн засагт томоохон худалдан авагч болдог гэдэг утгаар эдийн засгийн өрнөлд чухал нөлөөтэй билээ.

- **Татвар:** Татвар нь тусдаа бодлогын түвшинд хэрэгждэг ба нэг талаас айл өрх болон компанийн цэвэр ашигт нөлөөлдөг бол нөгөө талаас худалдан авалт буюу эрэлтийг өөрчилдөг.
- **Шилжих төлбөр:** Засгийн газраас иргэдэд ажилгүйдлийн тэтгэмж, хүүхдийн мөнгө зэрэг халамжийн төлбөр, татаасыг олгож, дэмжлэг үзүүлж болдог ба энэ нь эдийн засагт чухал нөлөөтэй юм.

ТӨСВИЙН ТЭЛЭХ БА ХУМИХ БОДЛОГО

Төсвийн дискрет бодлогыг хоёр ангилна.

Төсвийн тэлэх бодлого

- Төсвийн тэлэх бодлогыг ихэвчлэн ажилгүйдлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлдэг (Засгийн газрын зардлыг өсгөх, эсвэл татварыг бууруулах)

Төсвийн тэлэх бодлого буюу зардал өсөх

Эх сурвалж: Зохиогчид

Төсвийн хумих бодлого

- Инфляцыг бууруулахад чиглэгддэг (Засгийн газрын зардлыг бууруулах, эсвэл татварыг өсгөх)

Төсвийн хумих бодлого буюу зардал буурах

Эх сурвалж: Монголбанк

ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ

02

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГСЛҮҮД БА МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ

ДЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГСЛҮҮД

Төв банк нь мөнгөний бодлогын зорилготой уялдуулан мөнгөний бодлогын олон арга хэрэгслийг ашигладаг. Мөнгөний бодлогын арга хэрэгслийг мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөх байдлаар нь шууд ба шууд бус арга гэж ангилна.

Шууд аргад арилжааны банкны зээлийн үлдэгдэлд хязгаарлалт тогтоох, хүүний түвшнийг өөрчлөх зэрэг арга орох бөгөөд мөнгөний нийлүүлэлтийг богино хугацаанд багасгах зорилго тавьсан үед хэрэглэдэг.

Шууд бус аргад:

- **Заавал байлгах нөөцийн хэмжээ:** Арилжааны банк нь хадгаламж татах эрх бүхий этгээд бөгөөд үүнийг бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө гэж үзнэ. Банк бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөөс тодорхой хэсгийг бэлэн нөөц хэлбэрээр байлгавал зохих ба Төв банкнаас тогтоож өгсөн хамгийн доод хэмжээг "заавал байлгах нөөц" гэнэ. Заавал байлгах нөөц нь мөнгөний нийлүүлэлт буюу эдийн засаг дахь мөнгөний хэмжээтэй урвуу хамааралтай үзүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, заавал байлгах нөөцийн хувь өсөхөд мөнгөний нийлүүлэлт буурдаг.

Эндүүрэл буюу зардлын суваг



- **Нээлттэй захын арилжаа:** Банкны нөөцийг удирдах зорилгоор Төв банкнаас нэг жил хүртэл хугацаатай үнэт цаас гаргах, түүнийг худалдах болон худалдан авах үйл ажиллагааг хэлнэ. Мөн үүн дээр Засгийн газрын өрийн бичиг болон Төв банкнаас хүлээн зөвшөөрөгдсөн бусад үнэт цаасыг мөнгөний зах зээл дээр худалдах, худалдан авах үйл ажиллагаа багтана.
- **Хүүний нэгдсэн бодлого**: Төв банк нь өөрөө гаргаж буй үнэт цаасны хүүгээр дамжуулан Засгийн газар болон арилжааны банкны зээл, хадгаламжийн хүүд нөлөөлөх замаар мөнгөний нийлүүлэлтийг хянах аргыг "хүүгийн нэгдсэн бодлого" гэнэ.

- **Төв банкны зээлжүүлэлт:** Төв банк дээрх арга хэрэгслээс гадна арилжааны банк болон Засгийн газарт олгох зээлийн хэмжээнд тодорхой хяналт тогтоосноор мөнгөний бодлогын зорилтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, зээлд зохицуулалт хийснээр мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлдөг.



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний бодлогын арга хэрэгслүүд



Эх сурвалж: Монголбанк

1. НЭЭЛТТЭЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм.

Банк хоорондын захын богино хугацаат хүү болон нөөцийн өөрчлөлтийг удирдах зорилгоор хэд хэдэн төрлийн ТБҮЦ-ыг арилжааны банканд арилжаалдаг. Ингэхдээ нөхцөл байдлаас хамаарч хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэр нь харилцан адилгүй өөр өөр төрлийн үнэт цаасыг зах зээлд нийлүүлнэ.

Зорилго:

- Банк хоорондын зах (БХЗ)-ын тэнцвэрт байдлыг хадгалах;
- БХЗ-ын хүүний хэлбэлзлийг бууруулах;
- БХЗ-ын хүүний зорилтот түвшнийг хадгалах.

Төв банкны үнэт цаасны төрөл:

ТБҮЦ анх 1993 онд арилжаалагдаж эхэлсэн ба одоогийн байдлаар Монголбанкнаас 4 долоо хоног болон 28 долоо хоногтой ТБҮЦ-ыг тус тус арилжаалж байна.

Монгол Улсын Төв банкны үнэт цаасны төрөл

Хугацааны төрөл	Одоогоор арилжаалж байгаа эсэх
1 долоо хоног	-
4 долоо хоног	+
12 долоо хоног	-
28 долоо хоног	+
Бусад*	-

Эх сурвалж: Монголбанк

*Тайлбар: * ТБҮЦ-ны тухай журмаар Монголбанк 1 жил хүртэл хугацаатай ТБҮЦ-ыг арилжаалж болох бөгөөд энэхүү заалтын хүрээнд ямар ч төрлийн хугацаатай үнэт цаас арилжаалах боломжтой ажээ.*

ДӨРВӨН ДОЛОО ХОНОГТОЙ ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Харьцангуй урт хугацаатай санхүүгийн хэрэгслийг мөнгөний зах дээр бий болгох угтвар нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Монголбанк 2013 оны 3 дугаар сард дөрвөн долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-ыг хэрэгжүүлсэн байна. Харьцангуй богино хугацаатай ТБҮЦ-ны хэмжээг хязгаарлахгүйгээр арилжаалах нь банк өөрийн хүлээлтийн дагуу нөөцийн удирдлагаа хэрэгжүүлж, БХЗ-д нөөцийн хэт илүүдэл болон дутагдлаас үүдэх хүүний хэлбэлзлээс сэргийлдэг байна.

Тус үнэт цаасны өгөөж буюу хүү нь бодлогын хүүнээс хамаарах бөгөөд арилжааг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр, Даваа гараг бүрд зохион байгуулдаг.

28 ДОЛОО ХОНОГТОЙ ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

Монгол Улсын эдийн засгийн онцлогоос хамаарч, БХЗ-ын нөөцийн илүүдэл нь байнгын буюу бүтцийн шинжтэй байдаг. Засгийн газрын үнэт цаасны анхдагч захын арилжаа 2017 оны 11 дүгээр сараас хойш

зохион байгуулагдаагүй тул Монголбанкнаас журмын хүрээнд 28 долоо хоногтой буюу харьцангуй урт хугацаатай ТБҮЦ-ыг 2018 оны 11 дүгээр сараас эхлэн арилжаалж эхэлсэн ажээ. Энэхүү үнэт цаасыг арилжаалах нь дараах давуу талтай. Үүнд:

- БХЗ-ын байнгын буюу бүтцийн шинжтэй илүүдэл нөөцийг удирдах;
- Банк, санхүүгийн салбарт дутагдалтай байгаа дотоодын түргэн хөрвөх чадвартай активын үүргийг гүйцэтгэх;
- Заавал байлгах нөөц хангалтын хугацаатай уялдаж байдаг тул банк нөөцийн удирдлагад ашиглах;
- Арилжааны хэлбэр нь хүүг зах зээлийн зарчмаар тогтоох;
- Төгрөгийн өгөөжийн муруйн эхлэл болох зэрэг ач холбогдолтой юм.

Хорин найман долоо хоногтой ТБҮЦ-ыг Монголбанкны нөөцийн таамаглалд үндэслэн, хэмжээ болон хүүний дээд хязгаарыг тогтоож, хүүгээр өрсөлдүүлэх хэлбэрээр зохион байгуулдаг. ТБҮЦ-тай холбоотой үйл ажиллагааг "Төв банкны үнэт цаасны арилжааны журам"-аар зохицуулдаг байна.

Нээлттэй захын үйл ажиллагаа (ТБҮЦ болон Репо арилжаа)

Эх сурвалж: ҮСХ

2. ТӨВ БАНКНЫ САНХҮҮЖИЛТ

Төв банкны санхүүжилт нь БХЗ-д үүссэн нөөцийн түр зуурын дутагдлыг арилгах, илүүдэл нөөцийг шингээх зорилготой. Өөрөөр хэлбэл, банкууд хоорондоо, эсвэл Төв банканд богино хугацаатай мөнгө хадгалах, эсвэл зээлэх үйл ажиллагаа үүнд хамаарна.

Төв банкны санхүүжилтийн төрөл:

- Өдрийн зээл;
- Репо санхүүжилт;
- Овернайт Репо санхүүжилт;
- Овернайт хадгаламж.

Төв банкны санхүүжилтийн төрөл

Санхүүжилтийн төрөл	Зорилго, давтамж, хугацаа, хүүний хэмжээ
Өдрийн зээл	**Зорилго**: Мөнгөний бодлогын зорилгоор бус зөвхөн төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах **Давтамж**: Өдөр бүр нээлттэй **Хугацаа**: Тухайн өдөртөө буцаан төлөгдөнө **Хүү**: Хүүгүй
Репо санхүүжилт	**Зорилго**: Мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг зорилтот түвшинд хүргэх, хүүний коридорын дээд хязгаар болох **Давтамж**: Даваа гараг бүр **Хугацаа**: 7 хүртэл хоног байх ба хэрэв 7-гоос дээш бол тусдаа тушаалаар **Хүү**: Бодлогын хүү дээр нэмэх нь хүүний коридорын нэгж хувьтай тэнцүү
Овернайт хадгаламж	**Зорилго**: Хүүний коридорын доод хязгаарыг тогтоох, өдрийн төгсгөлд банкнуудын илүүдэл нөөцийг шингээх **Давтамж**: Өдөр бүр нээлттэй **Хугацаа**: "Банксүлжээ" систем хаахаас дараагийн өдрийн "банксүлжээ" систем нээх хүртэл үргэлжилнэ. **Хүү**: Бодлогын хүүнээс хасах нь хүүний коридорын нэгж хувьтай тэнцүү

Овернайт репо санхүүжилт	**Зорилго**: Төлбөр тооцоо гүйцэтгэх мөнгөн хөрөнгө дутагдсан тохиолдолд дутагдлыг арилгах **Давтамж**: Өдөр бүр нээлттэй **Хугацаа**: "Банксүлжээ" систем хаахаас дараагийн өдрийн "банксүлжээ" систем нээх хүртэл үргэлжилнэ. **Барьцаа хөрөнгө**: Төв банкны үнэт цаас **Хүү**: Бодлогын хүү дээр нэмэх нь хүүний коридорын нэгж хувьтай тэнцүү

Эх сурвалж: Монголбанк

3. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН БУСАД ХЭРЭГСЛҮҮД

Хэрэгслийн нэр төрөл	Тайлбар
Заавал байлгах нөөц	**Зорилго**: Мөнгөний нийлүүлэлтийг хянах, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг зохицуулах **Хугацаа**: 14 хоног тутамд (дундаж үлдэгдэл) **Хувь**: 8% (төгрөг), 18% (валют)
Барьцаат зээл	**Зорилго**: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор эцсийн зээлдүүлэгчийн үүргийн хүрээнд олгох боломжтой **Хугацаа**: 90 хүртэл хоног (Шаардлагатай үед олгогдоно) **Барьцаа хөрөнгө:** Монголбанкны ЭУА-наас гаргасан барьцааны жагсаалтад орсон үнэт цаас (Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Хөгжлийн банкны вексель, Банкны хэвийн зээл гэх мэт)
Своп/Форвард хэлцлүүд	**Зорилго**: Ханшийн эрсдэлээс хамгаалах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх **Давтамж**: Тогтмол бус **Валютын своп**: өнөөдрийн ханшаар валют худалдан авч -> хугацааны эцэст тохиролцсон ханшаар валютаа зарах **Валютын форвард**: Өнөөдөр ханшаа тохироод тодорхой хугацааны дараа тохиролцсон ханшаар валют худалдан авах хэлцэл **Хугацаа**: ТБҮЦ-ны хугацаанаас хэтрэхгүй

Эх сурвалж: Монголбанк

ХҮҮНИЙ КОРИДОР ГЭЖ ЮУ ВЭ?

Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх заагийг тодорхойлдог Төв банкны хэрэгсэл юм.

Хүүний коридорыг нэвтрүүлж, мөнгөний бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгосноор богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой ажээ.

Хүүний коридорын өргөнийг Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр өөрчилнө. Коридорын дээд хязгаарыг овернайт репо санхүүжилтийн хүү (бодлогын хүү + нэгж хувь), харин доод хязгаарыг овернайт хадгаламжийн хүү (бодлогын хүү – нэгж хувь) тус тус тодорхойлно. Мөнгөний бодлогын хорооны 2023 оны I улирлын хурлын шийдвэрээр хүүний коридорыг бодлогын хүүнээс ±1 нэгж хувийн өргөнтэй байхаар тогтоожээ.

Монголбанкны бодлогын хүүний өөрчлөлт ба хүүний коридор (хувиар)

Эх сурвалж: Монголбанк

Бодлогын уг арга хэмжээг хэрэгжүүлснээр банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ

03

ИНФЛЯЦ

ИНФЛЯЦ ГЭЖ ЮУ ВЭ?

Инфляц гэдэг нь хэрэглээний сагсыг бүрдүүлж буй бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өсөхийг хэлэх бөгөөд хийлэх, томрох гэсэн утгатай үг юм.

Инфляц өсөхөд нэг талдаа барааны үнэ өсөж байгаа ч нөгөө талдаа мөнгөний худалдан авах чадвар буурч байдаг. Жишээлбэл, "Атар" талхны үнэ 2021 онд 1,500 төгрөг байсан бол 2022 онд 1700 төгрөг болж, 1.1 дахин өссөн байхад, мөнгөний худалдан авах чадвар харин урвуугаар 1.1 дахин буурчээ.

Тухайн жилийн үнийн түвшнийг 'P_1', өмнөх жилийн үнийн түвшнийг 'P_0' гэвэл тухайн жилийн инфляц:

$$\frac{(P_1 - P_0)}{P_0} \times 100$$

Тэгэхээр атар талхны үнийн хувьд P_1=1,700 P_0=1,500 бөгөөд

$$\frac{(1{,}700 - 1{,}500)}{1{,}500} \times 100 = 13.3\%$$

буюу энэ бүтээгдэхүүний үнэ жилийн дотор 13.3 хувиар өссөн байна.

Гэхдээ инфляцыг зөвхөн нэг барааны үнийн өсөлтөөр биш хүмүүсийн голлон хэрэглэдэг хэд хэдэн төрлийн бараа, үйлчилгээний үнийн дундаж түвшний өөрчлөлтөөр хэмжинэ. Ингэхдээ хүн амын өргөн хэрэглээний гол нэрийн бараа, үйлчилгээг сонгон авч, тэдгээрийн үнийн дундаж өөрчлөлтийг тооцдог. Сонгон авсан эдгээр бараа, үйлчилгээг **ХЭРЭГЛЭЭНИЙ САГСНЫ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** гэнэ.

ХЭРЭГЛЭЭНИЙ САГС

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ноос айл өрхүүдийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр хэрэглээний барааны сагсны бүтцийг тодорхойлдог.

Монгол Улсын хэрэглээний сагс өнөөгийн байдлаар нийт 13 бүлгийн 410 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна. Хэрэглээний сагсанд 2023 оны нэгдүгээр сард өөрчлөлт оруулсан ба үүний өмнө тус сагс 12 бүлгийн 373 төрлийн бараа, үйлчилгээнээс бүрдэж байжээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ САГСЫГ БҮРДҮҮЛЖ БУЙ 13 БҮЛГИЙН БАРАА ӨӨР ӨӨР ЖИНТЭЙ БАЙДАГ. ЭНЭ ТАЛААР ТАЙЛБАРЛАНА УУ?

Хэрэглээний сагсан доторх бараа, үйлчилгээ харилцан адилгүй бөгөөд үүнээс хамааралтай хүмүүсийн худалдан авалтад нөлөөлж байгаа жин буюу инфляцад оруулах хувь нэмэр нь харилцан адилгүй байна.

Жин гэдэг нь өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь хэмжээ юм. Бага жинтэй барааны үнэ огцом нэмэгдсэн ч инфляцын түвшинд тодийлөн нөлөөлдөггүй бол жин дардаг барааны үнийн хөдөлгөөн инфляцын өөрчлөлтийн дийлэнхийг тодорхойлж байдаг.

Монгол Улсад энэхүү жинг харгалзан үзэж, хэрэглээний үнийн индекс (ХҮИ) гэсэн аргачлалаар инфляцыг тооцдог. Иймд дараах хүснэгтэд ХҮИ буюу хэрэглээний сагсанд багтах 13 бараа, үйлчилгээний жинг харуулж байна.

Хэрэглээний сагсанд багтах бүтээгдэхүүний нэр төрөл, жин

Нэр төрөл	Жин
Ерөнхий индекс	100.0
01. Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	25.1
02. Согтууруулах ундаа, тамхи	1.2
03. Хувцас, бөс бараа, гутал	12.3
04. Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	10.3
05. Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	5.4
06. Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	7.3
07. Тээвэр	16.3
08. Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	5.9
09. Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	1.9
10. Боловсролын үйлчилгээ	5.2
11. Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.9
12. Даатгал, санхүүгийн үйлчилгээ	0.5
13. Бусад бараа, үйлчилгээ	5.7

Эх сурвалж: ҮСХ

ИНФЛЯЦЫГ ТӨВ БАНК ТООЦДОГ УУ, ҮСХ-ООС ТООЦДОГ УУ?

Хэрэглээний үнийн албан ёсны тоон мэдээллийг зөвхөн ҮСХ гаргах эрх, үүрэгтэй. Харин Монголбанк нь ҮСХ-оос гаргасан албан ёсны мэдээлэлд тулгуурлан нийлүүлэлтийн гаралтай, нэг удаагийн шинжтэй үнийн өөрчлөлтийг хасаж, суурь инфляц гэсэн үзүүлэлтийг тооцон гаргадаг. Улс орнуудын Төв банк мөнгөний бодлогоо боловсруулахдаа суурь инфляц гэсэн үзүүлэлтийг түгээмэл хэрэглэдэг байна.

ИНФЛЯЦ 7.9 ХУВИАР ӨСЛӨӨ, 6.4 ХУВИАР ӨСЛӨӨ ГЭЖ ЯНЗ ЯНЗААР ЯРИХ ЮМ. ҮҮНИЙГ ЮУ ГЭЖ ОЙЛГОХ ВЭ?

Үнийг ямар цаг хугацааны үеэр авч үзэж байгаагаас шалтгаалан сарын, оны эхнээс, жилийн өөрчлөлт гэж авч үздэг.

Сарын инфляц гэдэг нь өмнөх сараас үнэ хэдэн хувиар өссөнийг харуулна. Оны эхнээс гэвэл 1 дүгээр сарын 1-нээс хойш үнэ хэдэн хувиар өссөнийг харуулна. Харин жилийн инфляц гэдэг нь үнэ өмнөх оны мөн үеэс хэдэн хувиар өссөнийг харуулах үзүүлэлт юм. Жишээлбэл, 2024 оны 2 дугаар сарын байдлаар жилийн инфляц 7.0%-д хүрлээ гэдэг нь 2024 оны 2 дугаар сард зах зээл дээр зарагдаж буй 410 бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг 2023 оны 2 дугаар сард зарагдаж байсан үнэтэй харьцуулаад 7.0%-аар өссөн байгааг илэрхийлнэ.

Инфляцын өөрчлөлт (сарын, оны эхнээс, жилийн)







Эх сурвалж: ҮСХ

ИНФЛЯЦААС ӨӨР ҮНИЙН ХЭМЖҮҮР БАЙХ УУ?

Монгол Улсад инфляцыг ихэвчлэн хэрэглээний үнийн индексээр тооцдог нь үнийн өөрчлөлтийг хэмждэг нэг үзүүлэлт юм.

Үүнээс гадна үйлдвэрлэгчийн үнийн индекс, импортын барааны үнийн индекс, экспортын барааны үнийн индекс, орон сууцны үнийн индекс, дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятор гэд үнийг хэмждэг олон үзүүлэлт бий. Тухайлбал, дотоодын нийт бүтээгдэхүүний дефлятор нь тухайн оронд зөвхөн хэрэглэсэн төдийгүй үйлдвэрлэсэн бүх бараа, үйлчилгээний өртгийг хамруулдаг. Иймд импортын бүтээгдэхүүний үнийн нөлөө ХҮИ дээр ажиглагддаг бол ДНБ-ий дефляторт нөлөөлдөггүй.

ИНФЛЯЦЫГ ХЭРХЭН АНГИЛДАГ ВЭ?

Инфляц нь хурд, хамрах хүрээ, цаг үе, шалтгаан, хүлээлт зэргээс нь хамаарч олон янз байна.

Шалтгаанаар нь:

Дефляц – Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшинд үргэлжлэн буурах үзэгдэл юм. Инфляцын түвшин тэг хувиас доогуур (хасах инфляц) болох үед тохиолдоно. Инфляцын хурдац буурах үзэгдэл (дисинфляц)-тэй андуурч болохгүй.

- Эрэлтийн гаралтай инфляц – Нийт эрэлтийн түвшин өссөнөөс үүсэх үнийн өсөлтийг хэлнэ.

- Нийлүүлэлтийн гаралтай инфляц – Нийт нийлүүлэлт буурах зэрэг өөрчлөлтөөс үүсдэг инфляцыг хэлнэ.

Нийлүүлэлтийн механизм алдагдах, хүчин зүйлийн үнэ өсөх зэрэг хүчин зүйлээс хамааран нийт нийлүүлэлт гэнэт буурдаг.

Өсөлтийн хурдаар нь:

- Дефляц: <0%
  - Мөлхөө: <3%
  - Аядуу: 3%-10%
  - Цогио: >10%
  - Гипер инфляц: >50% (сард!) гэж ангилна.

БОДЛОГЫН ХҮҮ ИНФЛЯЦАД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Төв банкны үнэт цаас нь банкны нөөцийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд Монголбанкны мөнгөний бодлогын үндсэн хэрэгсэл юм. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь Монголбанкны бодлогын хүү болох бөгөөд банк хоорондын зах дээр хөтөч хүүний үүргийг гүйцэтгэдэг.

Төв банкны бодлогын хүү нэмэгдэхийн хэрээр Монголбанкинд байршиж буй арилжааны банкны харилцах дансны төгрөгийн нөөц нэмэгддэг. Ингэснээр гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ саарч, барааны үнэ нэмэгдэх дарамт сулардаг. Улс орнуудын төв банк ч мөн адил инфляцтай тэмцэхдээ мөнгөний үнэ цэн буюу бодлогын хүүгээ нэмэгдүүлж инфляцыг нам тогтвортой түвшинд байлахыг эрмэлздэг.

МОНГОЛБАНКНААС ТООЦОН ГАРГАДАГ СУУРЬ ИНФЛЯЦ ЧУХАМ ЯМАР ҮҮРЭГТЭЙ ВЭ?

Хэрэглээний сагсанд зарим бараа, үйлчилгээнд улирлын нөлөөнөөс үүдэлтэй үнийн хэлбэлзэл их байдаг. Гэтэл ийм барааны үнийн хөдөлгөөн нь эдийн засаг дахь нийт үнийн хөдөлгөөнийг бүрэн төлөөлж чадахгүй байх, эсвэл бүдгэрүүлэх магадлалтай.

Эрэлтийн гаралтай инфляц нь иргэдийн худалдан авалт нэмэгдэх

буюу нийт эрэлт өсөх хандлагыг илэрхийлж байдаг тул Төв банк мөнгөний бодлогоор дамжуулж хариу үйлдэл үзүүлэх нь илүү нийцтэй. Харин дээр дурдсан улирлын нөлөөгөөр нийлүүлэлтэд өөрчлөлт гарч, богино хугацаанд үнэ өөрчлөгдөх үед мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглах нь төдийлөн тохиромжтой биш. Ийм учраас Төв банкнаас улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү болон хүнсний ногооны дэд бүлгийг ХҮИ-ийн сагснаас хасч инфляцыг дахин тооцож, эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин хаашаа хөдөлж байгааг тодорхойлдог юм. Тус үзүүлэлтийг суурь инфляц гэх бөгөөд суурь инфляц өсөөд эхэлбэл Төв банкнаас түүний эсрэг арга хэмжээ авах магадлал өндөр болдог.

Нийслэлийн ерөнхий болон суурь инфляц

Эх сурвалж: Монголбанк

ИНФЛЯЦ ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР СӨРӨГ НӨЛӨӨТЭЙ ВЭ?

- Зах зээлийн үр ашиггүй байдлыг нэмэгдүүлж, компаниуд цаашдын төсөв, төлөвлөгөөгөө гаргахад хүндрэлтэй;
- Мөнгөний ирээдүйн худалдан авах чадвар тодорхойгүй байх нь хөрөнгө оруулалт, хуримтлал хийх сэдлийг бууруулдаг;
- Эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлнө;
- Тогтмол орлого буюу цалингийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлж, орлогын хуваарилалт хийхэд хэцүү болно;
- Төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлнө;
- Инфляцын хүлээлтэд тодорхойгүй байдал үүсэж, сөргөөр нөлөөлж байдаг.

ДЕФЛЯЦ ГЭЖ ЮУ ВЭ?

Дефляц нь инфляцын эсрэг зүйл бөгөөд үнийн ерөнхий түвшин буурах үйл явц юм.

Энэ үзэгдэл нь бараа, үйлчилгээг худалдан авах хүмүүсийн эрэлт, хэрэгцээ буурснаар үйлдвэрлэгч компаниудыг өөрсдийн бүтээгдэхүүнийг хямд үнээр борлуулж, алдагдал хүлээхэд хүргэдэг үр дагавартай.

ИНФЛЯЦТАЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

1. Мөнгөний бодлого

Өмнөх бүлэгт дурдсан мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглах боломжтой. Гэхдээ мөнгөний бодлогын хэрэгжилт бодит эдийн засагт хоцрогдолтой хүрдэг тул мөнгөний бодлого хэрэгжүүлнэ гэдэг спидометр нь буруу заадаг, тоормос хэзээ барих нь тодорхойгүй, зам нь арын толинд харагддаг машин жолоодохтой адил аж.

2. Төсвийн бодлого

- Үр ашиггүй зардлаа бууруулах;
- Төсвийн алдагдал бууруулж, ашигтай гаргах;
- Хуримтлал өсгөх;
- Улсын өрийг зүй зохистой удирдах гэх мэт.

3. Бусад арга хэмжээ

- Дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, нэмэгдүүлэх;
- Төлбөрийн тэнцлийн алдагдлыг хязгаарлах;
- Цалингийн өөрчлөлтөд урьдчилсан төлөвлөгөөтэй хандах.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХҮҮ ӨНДӨР БАЙГАА НЬ ИНФЛЯЦТАЙ ХОЛБООТОЙ ЮУ?

Жишээлбэл, инфляц жилийн 8 хувь байна гэж бодъё. Та банканд мөнгөө жилийн 6 хувийн хүүгээр хадгалуулах уу? Хадгаламжийн хүү инфляцаас бага түвшинд байгаа үед хүмүүс өөр төрлийн зүйлд хөрөнгө оруулалт хийх нь ихэсдэг. Учир нь инфляцын түвшин хадгаламжийн хүүнээс өндөр байгаа үед хадгаламж эзэмшигчид бодит хүүний орлого орж ирэхгүй гэсэн үг юм.

Иймдээ ч хадгаламжийн хүү инфляцаас өндөр тогтож байж, иргэд банканд мөнгөө хадгалуулна. Харин хадгаламж эзэмшигчдийн мөнгийг банк зээл болгон гаргахдаа үйл ажиллагааны зардал, зээлийн эрсдэлийн зардал зэргийг нэмдэг учраас зээлийн хүү хадгаламжийн хүүнээс өндөр тогтдог.

Энгийнээр бол инфляц буурснаар хадгаламж, зээлийн хүү буурах боломжтой.

Инфляц ба хадгаламжийн хүүний хамаарал

Фишерийн тэнцэл: Нэрлэсэн хүү = Бодит хүү + Инфляцын хүлээлт
Өндөр инфляц → Инфляцын хүлээлт нэмэгдэнэ → Хүү нэмэгдэнэ

Эх сурвалж: Зохиогчид

ИНФЛЯЦЫН ӨСӨЛТ ИРГЭДЭД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ?

Инфляц өндөр байх нь таны орлого буюу мөнгө төдий чинээ үнэгүйдэж байна гэсэн үг. Ингэснээр иргэдийн худалдан авах чадвар буурч, хадгаламжийн бодит үнэ цэнд сөргөөр нөлөөлж, хөдөлмөрлөх сонирхолгүй болж, үйлдвэрлэл саарч, улмаар ядуурал нэмэгдэх аюултай.

Үнийн өсөлт, нэгдүгээрт, олон бараа, үйлчилгээ дээр ажиглагдаж байгаа; хоёрдугаарт, тасралтгүй ужгирсан шинжтэй байгаа бол илүү их анхаарал хандуулах ёстой. Нэг, эсвэл цөөн бараан дээр ажиглагдах нэг удаагийн буюу улирлын шинжтэй харьцангуй үнийн өсөлтөд мөнгөний бодлогын арга хэрэгслийг ашиглахад төвөгтэй юм.

Нэг удаагийн шинжтэй үнийн өсөлтөд эдийн засаг өөрөө тохируулга хийдэг. Эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин тогтвортой үед нийгмийн зүгээс зарим нэг барааг илүү хүсэмжилж болно. Энэ нь тухайн барааны эрэлтэд нөлөөлж, улмаар үнийг өсгөнө. Тэрхүү барааг үйлдвэрлээд хүртэх ашиг нэмэгдэх тул бизнесүүд тэр барааг үйлдвэрлэж эхэлнэ. Улмаар нийлүүлэлт нэмэгдэж, үнэ нь эргээд буурах нөхцөл болдог. Энэ үед нөөцийг зохистой хуваарилах зах зээлийн суурь зарчим үйлчилж байна.

Тиймээс үнэ өслөө гэдгийг зөвхөн сөргөөр ойлгож болохгүй. Бодит амьдрал дээр тухайн барааны чанар, үйлчилгээ нь сайжирсны улмаас үнэ нэмэгдэж болно. Иймээс инфляцын түвшин өссөн тохиолдол бүрд эдийн засаг буруу ажиллаад байна гэж дүгнэж болохгүй юм. Харин инфляцын өсөлтийн учир шалтгаан болон цаашид хэрхэн даамжрах вэ? гэдгээс бүх зүйл хамаарна.

ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ

04

ЗЭЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

ЗЭЭЛ

Зээл гэдгийг энгийнээр тодорхойлбол, санхүүгийн байгууллага, эсвэл хувь хүнээс хувийн хэрэгцээнд болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг тодорхой хугацаатайгаар хүү төлж, эргүүлэн өгөх нөхцөлтэй авсан мөнгө юм.

Зээлийг зориулалт болон эргэн төлөгдөх эх үүсвэрийн хэлбэрээс нь шалтгаалан дараах байдлаар ангилсан байдаг.

Зээлийн төрөл

Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ СОНГОХ

Ямар төрлийн зээлийг сонгох нь таны хэрэгцээ, шаардлагад нийцсэн, эрсдэлгүй, үр ашигтай байхыг урьдчилан судлах хэрэгтэй. Та зээл авах тухай бодохоос өмнө зээлийг хэрхэн, юунд зарцуулахаа тодорхойлсон байхаас гадна зээлийг хүүний хамт тогтмол давтамжтайгаар буцаан төлөх ирээдүйн орлогоо тооцоолсон байх ёстой.

Иймд зээл авахдаа дараах хүчин зүйлийг тодорхойлох нь зүйтэй.

Зээл авахад анхаарах хүчин зүйл

Эх сурвалж: Монголбанк

ЗЭЭЛИЙН ХҮҮ, ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ

Зээл авахаар төлөвлөж байгаа иргэд сар, улиралд буцаан төлөх зээл болон хүүний төлбөрийг урьдчилан тооцоолж, түүнийг төлж хүрэх мөнгөн орлогоо тооцоолдог анхан шатны чадвартай байх нь маш чухал.

Зээлийн эргэн төлөгдөх хуваарь:

Зээлийн хугацааны туршид зээл, түүний хүүний төлбөрийг тодорхой давтамжтайгаар хэсэгчлэн төлөх үүргийг тохиролцсон хуваарь

Зээлийн урьдчилсан төлөлт:

Зээлийн төлбөрийг хуваарьт хугацаанаас нь өмнө үндсэн зээлийг хэсэгчлэн болон бүтнээр нь буцаан төлөх.

Иргэдэд олгогдож байгаа ихэнх зээл ердийн, тогтмол хүүтэй байдаг. Та зээлийн хүүний зардлаа энгийн байдлаар тооцоолоход, таны үндсэн зээл буюу авсан зээлийн үлдэгдэл, тухайн зээлийн жилийн хүү, зээл ашиглах хоног мэдэгдэж байхад л хангалттай.

$$\textit{Зээлийн хүү} = \frac{\textit{Үндсэн зээл} * \textit{Зарласан хүү (хувь)} * \textit{хугацаа}}{365}$$

Жишээ №1.

Иргэн Алимаа iPhone гар утасны хамгийн сүүлийн загварыг худалдан авахаар 4.5 сая төгрөгийг жилийн 18 хувийн хүүтэй банкнаас зээллээ. Тэрбээр зээлээ 1 жил буюу 365 хоногийн дараа төлж дуусахаар гэрээ байгуулжээ.

$$810{,}000₮ = \frac{4{,}500{,}000₮ * 18\% * 365}{365}$$

Тэгэхээр Алимаа үндсэн зээлийн 4,500,000 төгрөг дээр 810,000 төгрөг буюу нийт 5,310,000 төгрөгийг төлөх шаардлагатай болно.

ХЭСЭГЧЛЭН ТӨЛӨХ БУЮУ ГРАФИК ЗОХИОХ

Зээлээ хэсэгчлэн төлөх үед өөрийн төлбөрийн чадвар, орлогоос хамаарч сар бүрийн нийт төлбөр тогтмол, эсвэл сар бүрийн үндсэн төлбөр тогтмол гэсэн хоёр хувилбараас сонголт хийх боломжтой юм.

Зээлийг хэсэгчлэн төлөх сонголт



Эх сурвалж: Зохиогчид

Сарын нийт төлбөр тогтмол үед сар бүр төлөх төлбөр нь жигд буюу дарамт харьцангуй бага байдаг. Гэхдээ нөгөө талдаа хугацааны эхэнд төлөгдөх үндсэн төлөлтийн хэмжээ бага байдаг тул нийт хугацааны туршид төлөх хүүний зардал өндөр байна. Харин сар бүр үндсэн

төлбөр тогтмол үед зээлдэгчийн эхний саруудын төлөх төлбөрийн дарамт өндөр боловч нийт хүүний зардал сарын нийт төлбөр тогтмол хувилбарыг бодвол бага юм.

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Ипотекийн зээл гэдэг нь үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан урт хугацаат зээл бөгөөд зээлдэгч нь урьдчилан тохирсон нөхцөлийн дагуу тодорхой хэмжээний төлбөрийг төлөх үүрэг хүлээсэн зээлийг хэлнэ.

Ипотекийн зээл нь зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд барьцааны үл хөдлөх хөрөнгөөр зээлийн төлбөрийг барагдуулах эрхийг зээлдүүлэгчид олгодог. Ипотекийн зээл болон Моргейжийн зээл нь хоёулаа орон сууцны зээл гэсэн утгатай.

Монголбанк болон Монгол Улсын Засгийн газар хамтран орон сууцны ипотекийн 8 хувийн зээлийн хөтөлбөрийг 2013 оны 6 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн билээ. Өдгөө тус хөтөлбөр нь 6 хувийн хүүтэй болохын зэрэгцээ нөхцөлүүдэд тодорхой өөрчлөлт орсон.

ХӨТӨЛБӨРИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгосноор иргэдийн орлого хэрэглээнээс хуримтлал руу шилжинэ. Иргэдийн хөдөлмөрийн хөлс, үнэлгээ, цаашлаад бүтээмж нэмэгдэж, эдийн засгийн ил тод байдал бүхэлдээ сайжрах давуу талтай.

Улмаар макро эдийн засгийн тогтвортой байдалд эергээр нөлөөлж, улс орны хэмжээнд хуримтлал нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.

"Н.Бат, эхнэр Б.Цолмонтой сард 2 сая төгрөгийн цалин авдаг. Н.Бат, Б.Цолмон хоёр өөрийн гэсэн байргүй тул аав,

ээжийнхээ хажуу өрөөнд амьдардаг байв. Тэд цалингийн дийлэнх хувийг хоол, хувцас, найзуудтайгаа уулзах зэрэгт зарцуулж, хуримтлал хийдэггүй байжээ.

Тэд саяхан орон сууцны зээлд хамрагдсанаар сар бүр цалингийнхаа тодорхой хувийг зээлдээ өгч, үлдсэн мөнгөөр амьжиргаагаа залгуулах шаардлага үүссэнээр тэдний санхүүгийн сахилга бат сайжирч эхэлжээ."

БУСАД ДАВУУ ТАЛ

- Зах зээлийн зарчимд суурилсан төрийн зохистой оролцоог бий болгох;
- Орон сууцны санхүүжилтийн тогтвортой, урт хугацааны тогтолцоог бэхжүүлэх;
- Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх;
- Орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх;
- Институциональ хөрөнгө оруулагчийг бий болгосноор үнэт цаасны захын хөгжлийг дэмжих;
- Агаарын бохирдлыг бууруулах, хүний хөгжлийн үндэс суурь болсон хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хүн амын амьдрах орчин, чанарыг сайжруулах.

ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН УРЬДЧИЛГАА ЯМАР АЧ ХОЛБОГДОЛТОЙ ВЭ?

Урьдчилгаа төлбөр нь зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтөд дарамт учруулахгүй байх, банкны салбарыг эрсдэлээс хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн чухал зохицуулалт юм.

ЗЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Зээлийн хугацаа 30 жил буюу 360 хүртэл сар;

- Зээлийн хүү – жилийн 6 хувь;
- Монгол Улсын иргэн, 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай байх;
- Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийн өр болон шүүхийн шийдвэрийн дагуу төлөх өр төлбөргүй байх;
- Үндсэн зээлдэгч нь төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл болон түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрт хамрагдаагүй байх;
- Урьдчилгаа төлбөр 30 хувиас доошгүй, зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 70 хувиас дээшгүй байх;
- Өрхийн өр, орлогын харьцаа (ӨОХ) татварын өмнөх орлогын 45 хувиас хэтрэхгүй байх;
- Орон сууцны талбай 80 м2-аас ихгүй байх;
- Зээлийн урьдчилан төлөлт хийх боломжтой;
- Бүрэн хорогдох, тогтмол хүүтэй байх;
- Барьцаа нь "Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам"-ын 2.6-д заасан шаардлагыг хангасан байх;
- Монголбанкнаас арилжааны банкнуудад хуваарилсан эх үүсвэрээр нэг зээлдэгчид олгох хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийн хэмжээ 100 сая төгрөгөөс хэтрэхгүй байна.

БАНКНУУДЫН ИРГЭДЭД ОЛГОСОН ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ ХЭД ХҮРСЭН БЭ?

2023 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар банкнуудын ипотекийн зээлийн үлдэгдэл 7,643.8 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 114,814-д хүрчээ.

Ипотекийн зээлийг эх үүсвэрээр нь задалж үзвэл, 68.0 хувь нь хөтөлбөрийн, 31.4 хувь нь банкны өөрийн, 0.7 хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн олголт (2019–2023 он)

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэхээр ажиллаж байгаа ба энэ хугацаанд ипотекийн зээл олголтод тасалдал үүсгэхгүй байхад анхаарч байна. Мөн хүн амын төвлөрлийг сааруулах, орон нутагт шилжин суурьшиж буй иргэдийг дэмжих ажлын хүрээнд орон нутагт олгогдох ипотекийн зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, 2023 оны 9 дүгээр сараас эхлэн хөдөө орон нутагт олгох ипотекийн санхүүжилтийг Улаанбаатар хотод олгогдох санхүүжилтээс багагүй байхаар шийдвэрлэж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийт ипотекийн зээлийн 17.1 хувь буюу 1,304.5 тэрбум төгрөгийн зээл орон нутагт ногдож байна.

Орон нутаг дахь зээл олголт (2023 оны эцсийн байдлаар)

Эх сурвалж: Монголбанк

ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ

05

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГ ГЭЖ ЮУ ВЭ?

Эдийн засгийн үйл ажиллагаа нь гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр цаг хугацааны турш заримдаа идэвхжиж, заримдаа буурч байдаг бөгөөд үүнийг эдийн засгийн мөчлөг буюу орчил гэнэ. Үүнийг маш энгийнээр хүний амьдралын мөчлөгтэй зүйрлэж болох ба үргэлжлэх хугацаа, эрчмээр өөр өөр байдаг.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн динамик өөрчлөлтийг харвал тэдгээр нь богино хугацаанд ихээхэн хэлбэлзэлтэй байдаг нь эдийн засгийн үйл ажиллагаа цаг хугацааны туршид заримдаа идэвхжиж, заримдаа буурч байдагтай холбоотой.

Эдийн засгийн мөчлөг

Эх сурвалж: Монголбанк

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГИЙН ҮЕ ШАТ

Эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжиж байвал өрнөлт, буурч байвал уналт гэж нэрлэнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа нь үйлдвэрлэлтэй нэгэн зэрэг өөрчлөгддөг тул түүнийг үйлдвэрлэлээр хэмжинэ.

Мөчлөг нь өрнөлт, уналтаас бүрдэнэ. Уналтын доод цэгээс оргил хүртэл эдийн засгийн өрнөлт үргэлжлэх ба оргилоос доод цэг хүртэл уналт үргэлжилнэ. Мөчлөгийн доод цэгээс урт хугацааны хандлага хүртэлх зайг "мөчлөгийн далайц" гэж нэрлэдэг.

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Эдийн засаг тэлж байгаа, эсвэл агшиж байгааг хэмждэг нэг чухал хэмжүүр бол дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) юм. Аливаа орны бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл нэмэгдэх үед эдийн засаг тэлж, ДНБ өсдөг.

ДНБ гэдэг нь: Тухайн бүс/улсын нутаг дэвсгэр дээр тайлант хугацаанд үйлдвэрлэгдсэн эцсийн бараа, бүтээгдэхүүн/үйлчилгээний нийлбэр дүнг ямар нэг валютаар илэрхийлсэн үзүүлэлт.

Жишээлбэл, Монгол Улсын ДНБ-ийг ҮСХ-оос тооцож гаргадаг ба нэрлэсэн, бодит, нэг хүнд ногдох гэсэн үзүүлэлтээр тайлагнадаг. Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн гэдэг нь нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг тухайн оны үнээр илэрхийлж байгаа бол "бодит" гэдэг нь нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг суурь оны үнээр илэрхийлж байгаа юм. Жишээлбэл, 2023 онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг 2023 оны үнээр илэрхийлбэл нэрлэсэн ДНБ гэнэ. Харин 2023 оны онд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг 2015 оны үнээр илэрхийлбэл бодит ДНБ гэнэ.

Бодит болон нэрлэсэн ДНБ-ний ялгаа



Эх сурвалж: ҮСХ

Дээр дурдсанчлан бодит ДНБ нь эдийн засгийн өсөлт, агшилтыг илүү сайн харуулдаг. Харин нэг хүнд ногдох ДНБ гэдэг нь тухайн оны ДНБ-ний дүнг хүн амын тоонд хуваасантай тэнцүү юм. Нэг хүнд ногдох ДНБ нь тухайн орны хүн амын амьжиргааны түвшнийг илэрхийлэх нэг үзүүлэлт болдог.

ЭДИЙН ЗАСГИЙН МӨЧЛӨГИЙН ҮЕД МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ТӨЛӨВ

Сэдэв 1-д макро эдийн засгийн бодлогын талаар тайлбарласан билээ. Эдийн засаг нь тогтмол нэг төлөвт байдаггүй ба гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр өсөж, буурдаг тул эдийн засгийн бодлогод заримдаа тохируулга, өөрчлөлт оруулах шаардлага тулгардаг.

Эдийн засгийн үйл ажиллагаа удааширч, уналтын үедээ орох үед аль болох хурдан арга хэмжээ авч сэргээх шаардлагатай байдаг. Сэргээхийн тулд төсөв, мөнгөний бодлогыг зөөлрүүлж болно. Харин эдийн засаг хэт хурдацтай өсөж, өрнөж эхэлбэл халалт үүсэх ба энэ нь бараа, үйлчилгээний үнийг өсгөх эрсдэлтэй юм. Хамгийн гол нь удирдлагагүй өсөлтийн үед үнийн хөөсрөлт бий болж, хөөс нь хэзээ нэг цагт гэнэт хагарч, маш хүчтэй уналт буюу хямралд хөтөлдөг.

Дэлхийн санхүүгийн хямралын үед үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсний хагаралт

Эх сурвалж: S&P Доу-Жонс Индекс ХХК

Макро эдийн засгийн бодлогыг тодорхойлохдоо урт хугацааны болон богино хугацааны төсөөлөл гаргах хэрэгтэй. Учир нь гаргасан бодлогын шийдвэр нь бодит эдийн засагт нөлөөлөхдөө хугацаа болон үйлчлэлийн хувьд харилцан адилгүй байдаг.

ТЭМДЭГЛЭЛ

СЭДЭВ

06

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТЫН ХАНШ ГЭЖ ЮУ ВЭ?

Валютын ханш гэдэг нь аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг өөр улсын мөнгөн тэмдэгтээр худалдах, худалдан авах "Үнэ" юм.

Валютын ханш нь тухайн валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдох ба бусад улс оронтой хийх бүх төрлийн эдийн засгийн харилцаанд ашиглагдаж, дотоодын эдийн засагт нөлөө үзүүлдэг макро түвшний үзүүлэлт тул нээлттэй эдийн засгийн хувьд чухал ажээ.

Ханшид нөлөөлдөг хүчин зүйл

Эх сурвалж: Зохиогчид

Валютын ханшийг ерөнхийд нь нэрлэсэн ба бодит гэж ангилна.

БОДИТ ХАНШ НЭРЛЭСЭН ХАНШААС ЯМАР ЯЛГААТАЙ ГЭЖ?

Нэрлэсэн ханш гэж тухайн улсын мөнгөн тэмдэгт (жишээлбэл, төгрөг)-ийг өөр нэг улсын валюттай харьцах ханшид ямарваа тохируулга хийлгүй шууд ашиглаж байгаа ханш юм. Харин бодит ханш гэдэг нь тухайн улсын мөнгөн тэмдэгтийг өөр улсын валюттай харьцуулах үед инфляцын нөлөөг оруулж тооцсон ханш юм. Энгийнээр бол нэрлэсэн ханшаас үнийн нөлөөг хасаж тооцох үед бодит ханш гарна.

Нэрлэсэн болон бодит ханш нь зөвхөн хоёр валютын хоорондох ханшийг хэмждэг бөгөөд эдийн засгийн хувьд тухайн орны валютын ханшийн өөрчлөлтийг бүрэн гүйцэт тайлбарлаж чаддаггүй. Тухайн орны валютыг өөр хэд хэдэн орны валюттай индексийн аргаар нэгтгэж харьцуулснаар энэхүү асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Нэрлэсэн үйлчилж буй ханш (Nominal effective exchange rate) гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханшийн индексүүдийн жигнэсэн дундаж ханш. Энэ нь дан ганц ам.доллар, евро гэлтгүй гадаад худалдааны түнш бүх орны мөнгөн тэмдэгттэй харьцах төгрөгийн нэрлэсэн дундаж ханшийг хэлнэ.

Нэрлэсэн үйлчилж буй ханшийг NEER гэж тэмдэглэнэ.

Бодит үйлчилж буй ханш (Real effective exchange rate) гэж гадаад худалдааны түнш орнуудын валюттай харьцах төгрөгийн бодит ханшийн индексүүдийн жигнэсэн дундаж буюу гадаад худалдааны түнш бүх улс орны үндэсний мөнгөн тэмдэгттэй харьцах төгрөгийн бодит дундаж ханшийг хэлнэ. Бодит үйлчилж буй ханшийг REER гэж тэмдэглэнэ.

$$\Delta REER = \Delta NEER + \text{Инфляц}$$

Бодит ханш



Эх сурвалж: Зохиогчид

ХАНШИЙН ДЭГЛЭМ

Улс орнуудад үйлчилж буй ханшийн дэглэмийг ерөнхийд нь 3 бүлэгт хуваах боломжтой.

- Тогтмол ханшийн дэглэм (Жишээлбэл, Бүгд Найрамдах Куб Улс, Хонконг, Арабын Нэгдсэн Эмират Улс гэх мэт);
- Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэм (Жишээлбэл, Австрали, АНУ, ИБУИНХУ гэх мэт);
- Удирдлагатай хөвөгч ханшийн дэглэм (Жишээлбэл, Монгол Улс, Турк, Индонез гэх мэт).

ТОГТМОЛ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Валютын тогтмол ханшийн дэглэмийн үед тухайн улсын Төв банк үндэсний валютын бусад улсын валюттай харьцах ханшийг тогтмол түвшинд барих бөгөөд үүний тулд Төв банк нь гадаад валютын хангалттай нөөцтэй байх шаардлагатай. Үүний нэг жишээ бол Хонконг доллар юм. Хонконг долларын ханшийг ам.доллартой уясан байдаг ба ингэхдээ 1 ам.доллар 7.80 орчим Хонконг доллар байхаар зохицуулсан. Тэгэхээр ам.долларын ханш унаж эхэлбэл Хонконгийн мөнгөний удирдах газар (Төв банк) зах зээл дээрээс ам.доллар худалдаж авч Хонконг доллар нийлүүлдэг. Харин ам.долларын ханш өсөх буюу чангарах үед ам.доллар зах зээл рүү нийлүүлж, Хонконг доллар худалдаж авдаг.

Давуу тал:

- Валютын ханш тогтмол байх тул тодорхой бус байдал бага;
- Импортын барааны инфляцын дарамт харьцангуй бага.

Сул тал:

- Мөнгөний бодлогын бие даасан байдал алдагддаг;
- Төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэрждэггүй;
- Зохицуулалтгүй валютын арилжаа үүсэх эрсдэлтэй.

ЧӨЛӨӨТЭЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Чөлөөтэй хөвөгч ханшийн дэглэмийн үед Төв банк үндэсний валютын ханшийг зах зээлд чөлөөтэй хэлбэлзэж байхыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд хөндлөнгөөс оролцохгүй.

Давуу тал:

- Мөнгөний бодлогын бие даасан байдал хангаж, эдийн засгийн нөхцөл байдалд тохируулан хэрэгжүүлэх боломжтой;
- Төлбөрийн тэнцэл зах зээлийн зарчмын дагуу тэнцвэржих нөхцөл бүрдэнэ.

Сөрөг тал:

- Ханшийн огцом хэлбэлзэл нь нийт эдийн засагт нөлөөлөх эрсдэлтэй;
- Импортын барааны инфляцын дарамтыг нэмэгдүүлдэг.

Уг дэглэм нь том зах зээлтэй хөгжингүй орнуудад илүү үр дүнтэй байдаг.

УДИРДЛАГАТАЙ ХӨВӨГЧ ХАНШИЙН ДЭГЛЭМ

Удирдлагатай хөвөгч ханшийн дэглэмийн үед валютын ханш зах зээлийн эрэлт, нийлүүлэлт буюу валютын урсгалаар тодорхойлогдох боловч зах зээл дээр ханшийн огцом хэлбэлзэл бий болсон үед Төв банк нь хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор интервенц хийж, нөлөөлдөг.

Давуу тал:

- Зах зээлийн ханшийн өөрчлөлтөд дасан зохицох, хүлээлтээ удирдах боломжийг олгосноор ААН-үүд цаашдын орлого, зарлагын тооцоог хийж, үйл ажиллагаагаа тогтвортой удирдан явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангана.

Сөрөг тал:

- Төв банк тодорхой хэмжээгээр гадаад валютын нөөцтэй байж, түүнийгээ тухай бүр зах зээлд нийлүүлэх шаардлагатай.

БОЛОМЖГҮЙН ГУРВАЛЖИН?

Нобелийн шагналт эдийн засагч Р.Манделл, Олон улсын валютын сан (ОУВС)-ын судалгааны захирал Ж.Флемин нар 1960-аад онд тус тусдаа судалгаа хийж, валютын ханшийн тогтвортой байдал, мөнгөний бие даасан бодлого, хөрөнгийн чөлөөт урсгал гэсэн гурван зорилт нэгэн зэрэг биелэх боломжгүй, эдгээрээс зөвхөн хоёр нь л нэгэн зэрэг биелэх боломжтой гэдэг дүгнэлтийг хийсэн байдаг. Улмаар үүнийг БОЛОМЖГҮЙН ГУРВАЛЖИН гэж нэрлэх болсон ажээ.

Валютын ханшийн боломжгүйн гурвалжин

Эх сурвалж: Trilemmas and tradeoffs: living with financial globalisation (Obstfeld, 2015)

Тогтмол валютын ханш, хөрөнгийн чөлөөт урсгал, бие даасан мөнгөний бодлогыг нэг дор хэрэгжүүлбэл санхүүгийн хямралд хүргэдэг гэж үздэг. Тухайлбал:

- Мексикийн Песо хямрал (1994–1995);
- 1997 оны Азийн санхүүгийн хямрал (1997–1998) ;
- Аргентины санхүүгийн хямрал (2001–2002).

Монгол Улсын хувьд хөрөнгийн чөлөөтэй урсгалтай буюу гаднаас орж гарах валютад ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүй. Нөгөө талаар, Төв банк нь инфляцыг зорилт болгосон байдаг тул валютын ханшийг тогтмол барих боломжгүй юм.

ВАЛЮТЫН ЗАХ

Монголбанк нь валютын дотоодын захад гадаад валютын дуудлага худалдаа буюу интервенцийн аргаар оролцдог. Интервенц нь валютын дотоодын захын үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх, валютын ханшийн огцом хэлбэлзлийг хязгаарлах, зах зээлийн зарчмаар тогтох бололцоог олгодог. Өөрөөр хэлбэл, шаардлагатай тохиолдолд Төв банкнаас валютын захад валют худалдах, худалдан авах үйл ажиллагаа явуулдаг.

Монголбанк нь гадаад валютын дуудлага худалдааг долоо хоног бүрийн Мягмар, Пүрэв гарагт тогтмол зохион байгуулдаг ба дуудлага худалдаанд зөвхөн банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй этгээд оролцдог. Дуудлага худалдааны мэдээлэл Монголбанкны цахим хуудсанд тухай бүр тавигддаг.

САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛҮҮД

Валютын захад оролцогчдыг ханшийн эрсдэлээс хамгаалахын тулд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг мөн ашигладаг.

Түгээмэл ашиглагддаг хэрэгслүүд:

- Своп хэлцэл – тухайн өдрийн ханшаар валют худалдан авч (эсвэл худалдаж), ирээдүйн тохиролцсон ханшаар эргүүлэн худалдах (худалдан авах) хэлцлийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, своп нь өнөөдөр валют аваад ирээдүйд төлөх хэлцэл юм.
- Форвард хэлцэл – талуудын хэлцлийн дагуу валютыг тохирсон үнээр тодорхой хугацааны дараа худалдах, худалдан авах үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь зөвхөн ирээдүйд валют авч, зарах хэлцэл юм.

2010 онд Монголбанкнаас своп, форвард хэлцлийг нэвтрүүлсэн...

Своп хэлцэл

- ***"Тогтмолын своп хэлцэл"*** *гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк тогтмол татаж, ам.доллар нийлүүлж хугацааны эцэст Монголбанк ам.доллар татаж, тогтмол нийлүүлэх хэлцлийг*
- ***"Ам.долларын своп хэлцэл"*** *гэж хэлцэл хийгдэх үед Монголбанк ам.доллар татаж, тогтмол нийлүүлж хугацааны эцэст Монголбанк тогтмол татаж, ам.доллар нийлүүлэх хэлцлийг*
- ***"Юаний своп хэлцэл"*** *гэж тодорхой хугацааны эцэст Монголбанк өөлэн бус тогтмолын зээлийн дүнг, хүүгийн хамт банкинд эргүүлэн төлөх, банк өөлэн бус юаний зээлийн дүнг хүүгийн хамт эргүүлэн төлөх нөхцөлтэй олгосон хэлцлийг ойлгоно.*

Форвард хэлцэл

- ***"Тогтмолын форвард хэлцэл"*** *Хугацааны эцэст Монголбанк тогтмол худалдан авч, ам.доллар худалдах хэлцлийг.*
- ***"Ам.долларын форвард хэлцэл"*** *Хугацааны эцэст Монголбанк ам.доллар худалдан авч, тогтмол худалдах хэлцлийг ойлгоно.*

Эх сурвалж: Монголбанк

ХАНШИЙГ ХЭН ТОГТООДОГ ВЭ?

Арилжааны банк, ББСБ зэрэг этгээд нь зах зээлийн зармаар ханшийг тогтоодог. Харин Монголбанк нь банкнуудын жигнэсэн дундаж ханшийг тооцож, Монголбанкны албан ханшийг зарладаг.

Монголбанкны албан ханшийг зөвхөн албан хэрэгцээнд буюу гааль, шүүх, нягтлан бодох, татвар зэрэгт ашиглана.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ

Улсын гадаад валютын албан нөөц нь төрийн эрх бүхий байгууллага болон арилжааны банкны эзэмшилд байгаа гадаадын банк, санхүүгийн байгууллагад хадгалж байгаа мөнгөжсөн алт, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют, гадаадын үнэт цаасны зах дээр чөлөөтэй борлогдох үнэт цаас болон бусад олон улсын хэмжээнд валютын нөөцөд тооцогдох үнэт зүйлээс бүрдэнэ.

Монголбанк эзэмшин, удирдаж байгаа гадаад валютын улсын нөөцийн гадаад төлбөрийг түргэн гүйцэтгэх чадвар, аюулгүй, найдвартай байдал зэргийг хангах үүрэгтэй ба эдгээр нь биелсэн цагт л нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж болно.

ГВАН = Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют.

ГВАН = Улсын үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэл, гадаад өр төлбөрийг барагдуулах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх баталгаа буюу гадаад секторын тогтворгүй байдлыг даван туулах хэрэгсэл.

СЭДЭВ

07

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Өмнөх сэдвээс валютын ханшийн талаарх ерөнхий ойлголтыг олж авсан билээ. Валютын ханшид нөлөөлөгч гол хүчин зүйлийн нэг бол "Төлбөрийн тэнцэл" бөгөөд энэ талаар дэлгэрүүлж судалъя.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Төлбөрийн тэнцэл бол тухайн орны эдийн засгийн гадаад бодлогын илэрхийлэл буюу нэрийн хуудас болдог. Төлбөрийн тэнцэл нь нэг талаас хэт мэргэжлийн, статистик шинжтэй үзүүлэлт мэт ойлгогддог ч, нөгөө талаас аливаа улс орны эдийн засгийн гадаад мөнгөн урсгал, тэнцлийг илэрхийлэгч, макро эдийн засгийн хамгийн чухал үндсэн нэг юм.

Хүмүүс төлбөрийн тэнцлийг гадаад худалдааны тэнцэлтэй андуурдаг. Гадаад худалдааны тэнцэлд зөвхөн экспорт болон импортын зөрүүг тооцдог бол төлбөрийн тэнцэл нь үүн дээр гадаадын хөрөнгө оруулалт, өр төлбөр, санхүүгийн үйлчилгээ гэх мэт үзүүлэлтийг нэмж тооцдог, илүү өргөн хүрээний ойлголт юм.

Олон улсын нийтлэг аргачлалын дагуу төлбөрийн тэнцэл гэж аливаа улсын эдийн засгийн харьяатын гадаад эдийн засагтай буюу эдийн засгийн харьяат бустай

Тодорхой хугацаанд хийсэн худалдаа, үйлчилгээ, хөрөнгө, санхүүгийн болон бусад урсгалын орлого, зарлагын гүйлгээг системчлэн нэгтгэсэн статистикийн тайланг хэлдэг.

Энэхүү статистик нэгтгэл нь аливаа улс орны гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг харуулахаас гадна, тус орны эдийн засгийн ерөнхий төлөв байдал, хандлагын талаарх мэдээллийг өгдөг.

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН БҮТЭЦ

Төлбөрийн тэнцэл нь үндсэн гурван бүлгийн данснаас бүрдэнэ. Үүнд:

1. Урсгал данс

- Гадаад худалдааны тэнцэл (экспорт, импорт);
- Үйлчилгээ (санхүү, даатгал, тээвэр, аялал жуулчлал г.м.) ;
- Цэвэр орлого (хүү, ногдол ашиг, цалин зэрэг орлого) ;
- Цэвэр шилжүүлэг (гадаад улс руу шилжүүлж, эсвэл орж ирж байгаа мөнгө, тусламж, тэтгэлэг).

Гадаад худалдааны тэнцэл ашигтай ч, урсгал данс алдагдалтай гарч болох ба энэ үед худалдаанаас бусад 3 үзүүлэлт сөрөг байна гэсэн үг юм.

2. Хөрөнгө ба санхүүгийн данс

2.1. Хөрөнгийн данс

- Хөрөнгийн шилжүүлэг (газар, орон сууц зэрэг хөрөнгийн өмчлөл шилжүүлэх);
- Үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг (тоног төхөөрөмжийн өмчлөл шилжүүлэх).

2.2. Санхүүгийн данс

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт (хувь хүн, эсвэл компани бизнесийн зорилгоор хийх хөрөнгө оруулалт);
- Багцын хөрөнгө оруулалт (хувьцаа, бонд гэх мэт);
- Бусад хөрөнгө оруулалт (үүсмэл хэрэгсэл зэрэг дээр багтаагүй бусад хөрөнгө оруулалт)

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН АЛДАГДАЛ

Төлбөрийн тэнцэл алдагдалтай байна гэдэг нь тухайн улсаас гарч байгаа мөнгө орж байгаа мөнгөнөөс давж, хасах дүнтэй байна гэсэн үг. Улмаар энэ нь гадаад валютын нөөц буурахад хүргэдэг. Хэрэв энэ нь даамжирвал импортын төлбөрийг хийж чадахгүйд хүрэх эрсдэлтэй болдог.

Төлбөрийн тэнцэлд урсгал данс чухал байр суурь эзэлдэг. Урсгал дансны тэнцэл нь энгийнээр монголчуудын гадаадад гаргаж худалдаалдаг бараа, үйлчилгээ, шилжүүлгийн орлогоос бусад оронд төлдөг ижил төрлийн зардлыг хассан дүн юм. Энэ үзүүлэлт алдагдалтай буюу хасах (–) утгатай байна гэдэг нь бидний олж байгаа валютын орлого нь бидний гадагш нь төлдөг валютад хүрэхгүй байна гэсэн үг. Монгол Улсын хувьд урсгал дансны тэнцэл алдагдалтай гарах тохиолдол их байгаа нь шийдвэрлэх шаардлагатай асуудлын нэг юм.

СЭДЭВ

08

МОНГОЛБАНКНЫ СТАТИСТИКИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Монголбанк нь хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу мөнгө, санхүү болон гадаад сектор зэрэг өргөн хүрээний статистикийг боловсруулж нэгтгэн олон нийтэд мэдээлдэг.

Монголбанкны статистикийн веб хуудас



Монголбанкны https://stat.mongolbank.mn/ цахим хуудаснаас дараах үндсэн тайлан, статистик үзүүлэлтийг харах боломжтой:

- **Мөнгө, санхүү**
    - Мөнгөний үзүүлэлт;
    - Мөнгөний тойм;
    - Банкнуудын нэгдсэн тайлан тэнцэл;
    - Хүү;
    - Ипотекийн зээл;
    - Валютын ханш.
- **Гадаад сектор**
    - Төлбөрийн тэнцэл;
    - Гадаад хөрөнгө оруулалт;
    - Гадаад өр;
    - Гадаад худалдааны тойм;
    - Гадаад секторын тойм.

- **Төв банкны статистик**
    - Төв банкны үнэт цаасны хүү;
    - Инфляц.
- **Статистикийн бюллетень**
- **Бусад**

ВАЛЮТЫН ХАНШ

Зах зээлийн үйл ажиллагаа -> Ханшийн статистик -> Монголбанкнаас зарласан валютын ханш

Цахим хуудасны дээр дурдсан хэсгээс Монголбанкнаас зарлаж байгаа ханшийн статистикийг дараах төрлөөр харах боломжтой:

- Төв банкны тухайн өдрийн албан ханш;
- Ханшийн хөдөлгөөн;
- Ханшийн сарын дундаж хөдөлгөөн;
- Нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханшийн индекс.

Анхаарах!

Монголбанк нь 2010 оны 12 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн "ТУХАЙН ӨДРИЙН ХААЛТЫН ХАНШ"-ийг зарлаж байгаа бөгөөд энэ ханшийг Монголбанкнаас зарласан дараа өдрийн ханш гэж тооцно.

Дурдаж буй ханшийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтад заасан Монголбанкнаас зарласан ханш гэж ойлговол зохино.

Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс нь энгийнээр төгрөгийн бусад худалдааны түнш орнуудын валютын эсрэг үнийн хөдөлгөөнийг илэрхийлнэ. Тус индексийн утга өсвөл төгрөгийн ханш чангарч байна гэж ойлгоно.

Бодит үйлчилж буй ханш нь худалдааны түнш орнууд ба Монгол Улсын инфляцаар засварласан төгрөгийн ханшийг илэрхийлнэ. Нэрлэсэн үйлчилж буй ханшаас инфляцын нөлөөг хасаж тооцвол төгрөгийн ханш ямар байгааг эндээс харж болно.

Нэрлэсэн болон бодит ханшийн талаарх мэдээллийг тус гарын авлагын "Валютын ханш" хэсгээс авна уу.

Монголбанкнаас зарласан валютын ханш

$ Өдрийн хаалтын ханш | Түүхэн ханш

2024 оны Дөрөвдүгээр сарын 29 өдрийн хаалтын ханш

USD	АНУ доллар	3,377.03	EUR	Евро	3,620.51	JPY	Японы иен	21.70
		-0.32			-3.59			0.15
CHF	Швейцар франк	3,704.71	SEK	Шведийн крон	309.41	GBP	Английн фунт	4,231.59
		1.48			-1.27			8.21
BGN	Болгарын лев	1,851.29	HUF	Унгарын форинт	9.23	EGP	Египетийн фунт	70.86
		-1.44			0.01			0.35
INR	Энэтхэгийн рупи	40.47	HKD	Хонконг доллар	431.48	RUB	ОХУ-ын рубль	36.34
		-0.06			0.06			-0.30
KZT	Казахстан тэнгэ	7.65	CNY	БНХАУ-ын юань	466.01	KRW	БНСУ-ын вон	2.45
		0.03			-0.10			— 0.00
KPW	БНАСАУ-ын	25.98	CAD	Канадын доллар	2,472.75	AUD	Австралийн доллар	2,216.34
		— 0.00			-1.68			6.54
CZK	Чех крон	143.94	TWD	Тайвань доллар	103.62	THB	Тайланд бат	91.10
		-0.30			-0.01			-0.30
IDR	Индонезийн рупи	0.21	MYR	Малайзын рингит	707.53	SGD	Сингапур доллар	2,483.57
		— 0.00			0.08			1.05
AED	АНЭУ-ын дирхам	919.45	KWD	Кувейт динар	10,972.40	NZD	Шинэ Зеланд доллар	2,014.40
		-0.06			0.57			1.67
DKK	Данийн крон	485.45	PLN	Польшийн злот	838.91	UAH	Украйны гривн	85.07
		-0.46			0.07			-0.21
NOK	Норвегийн крон	307.28	NPR	Непалын рупи	25.29	ZAR	Өмнөд Африкийн ранд	179.69
		-0.73			-0.04			2.10

Эх сурвалж: Монголбанк

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ТАЙЛАН

stat.mongolbank.mn -> **Мөнгө, санхүүгийн статистик**

Монголбанк нь сар бүрийн 20–24-нд арилжааны банкнуудын ипотекийн зээлийн тайланг нэгтгэн цахим хуудаснаа байршуулдаг.

Уг тайлангаас ипотекийн зээлд хамрагдсан нийт зээлдэгчийн тоо, зээлийн хүү, өмнөх оны мөн үе болон өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт зэрэг холбогдох тоог харах боломжтой.

Ипотекийн зээлийн тайлан



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН СТАТИСТИК

stat.mongolbank.mn -> **Гадаад сектор** -> **Төлбөрийн тэнцэл**

Төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позицын статистикийн асуудал нь өнгөц харахад "статистик" гэсэн утгаар техникийн шинжтэй асуудал гэж ойлгогдож магадгүй ч, энэ нь аливаа эдийн засгийн гадаад тэнцлийг илэрхийлэгч, макро эдийн засгийн хамгийн чухал үзүүлэлтийн нэг юм.

Төлбөрийн тэнцлийн статистикийг Монголбанк нь сар бүрийн 27–31-нд цахим хуудаснаа байршуулдаг.

Энэ нь Монгол Улсын эдийн засгийн харьяат ба харьяат бусын хооронд хийгдэж буй бүх төрлийн ажил, гүйлгээг тусгадаг. Төлбөрийн тэнцэл нь тухайн тайлант үеийн ажил, гүйлгээгээр тайлагнагддаг бол гадаад хөрөнгө оруулалтын позицын тайлан нь өссөн дүнгээр тайлагнагддаг.

Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)

Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦЫН ТАЙЛАН

stat.mongolbank.mn -> **Гадаад сектор** -> **Гадаад хөрөнгө оруулалтын позиц**

Гадаад хөрөнгө оруулалтын позицын тайланг Монголбанк улирлын давтамжтай 25-ны өдрийн дотор цахим хуудаснаа байршуулдаг. Өөрөөр хэлбэл, 2 дугаар сард өмнөх тайлан гарсан бол 5 сарын 25-аас өмнө дараагийн тайлан гарна.

Энэ нь төлбөрийн тэнцлийн тайлангийн санхүүгийн дансны үлдэгдлийг харуулдаг хэсэг юм. Тодруулбал, тайлант үеийн гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт нь мөн үеийн төлбөрийн тэнцлийн тайлангийн харгалзах дансны дүнтэй тэнцүү байна.

Төлбөрийн тэнцэл болон гадаад хөрөнгө оруулалтын позиц хоорондын хамаарал

Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

stat.mongolbank.mn -> **Гадаад сектор** -> **Монгол Улсын нийт гадаад өр**

Гадаад өрийн статистикийг Монголбанк улирал бүрийн дараагийн 2 дахь сарын 25-ны өдрийн дотор цахим хуудаснаа байршуулдаг (Жишээлбэл, 3 дугаар улирлын мэдээлэл 11 сарын 25-ны дотор гарна.)

Энэ нь Монгол Улсын хувийн болон улсын нийт гадаад өрийн хэмжээг илэрхийлдэг бөгөөд өссөн дүнгээр тайлагнагддаг.

Гадаад өр/ДНБ

Үзүүлэлт	2022/III	2023/III	өөрчлөлт		* %
			дүн	*хувь*	
Нийт гадаад өр	**32,515**	**33,991**	**1,476**	**5%**	**100%**
I. Засгийн газар	**7,645**	**7,871**	**226**	**3%**	**23%**
Бонд, өрийн бичиг	2,042	2,045	4	0%	6%
Зээл	5,603	5,743	140	2%	17%
II. Төв банк	**2,328**	**1,959**	**-369**	**-16%**	**6%**
III. Банк	**1,369**	**1,633**	**264**	**19%**	**5%**
Богино хугацаат	244	221	-23	-9%	1%
Урт хугацаат	1,125	1,411	287	25%	4%
IV. Бусад сектор	**9,007**	**8,516**	**-491**	**-5%**	**25%**
Богино хугацаат	1,721	1,642	-79	-5%	5%
Урт хугацаат	7,287	6,875	-412	-6%	20%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	**12,166**	**14,012**	**1,846**	**15%**	**41%**

**: Нийт өсөлтөд оруулсан хувь*

Эх сурвалж: Монголбанк

МӨНГӨНИЙ ТОЙМ

stat.mongolbank.mn -> **Мөнгө, санхүүгийн статистик**

Мөнгөний тоймд үнэ, мөнгө, зээл, мөнгөний зах болон валютын ханшийн статистикт гарсан өөрчлөлт, хандлагыг тайлбарлан танилцуулдаг. Эндээс мөн хадгаламж болон зээлийн үлдэгдэл, хүү зэрэг үзүүлэлтийн мэдээллийг авах боломжтой.

Монголбанк нь сар бүрийн 22–24-нд "Мөнгөний тойм"-ыг статистикийн цахим хуудаснаа байршуулдаг.

Мөнгөний тойм



Эх сурвалж: Монголбанк

БАНКНУУДЫН НЭГДСЭН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

stat.mongolbank.mn -> **Мөнгө, санхүүгийн статистик**

Банкнуудын нэгдсэн тайлан тэнцэл гэдэг нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бүх арилжааны банкны хөрөнгө, өр төлбөр болон өмчийн мэдээллийг тухайн өдрөөр нэгтгэн харуулсан санхүүгийн байдлын илэрхийлэл юм. Нэгдсэн тайлан тэнцлийн актив талд хөрөнгө, харин пассив талд өр төлбөр болон өөрийн хөрөнгийг бүртгэдэг:

Актив = Пассив + Өөрийн хөрөнгө

Тухайн банк нь санхүүгийн тайланг улирал бүр өдөр тутмын сонин хэвлэлээр дамжуулж иргэд, олон нийтэд мэдээлж байхаар Банкны тухай хуульд заасан байдаг.

Банкнуудын нэгдсэн тайлан тэнцлийг Монголбанк нь сар бүрийн 16-17-нд цахим хуудаснаа байршуулдаг.

СТАТИСТИК БЮЛЛЕТЕНЬ

stat.mongolbank.mn -> **Бюллетень**

Бюллетеньд Төв банк болон арилжааны банкнуудын нэгдсэн тайлан тэнцэл, мөнгөний тойм, зээлийн өрийн үлдэгдэл, ХҮИ, хадгаламж, зээлийн хүү, худалдааны тэнцэл, төсвийн гүйцэтгэл, үнэт цаасны зах зээлийн мэдээ зэрэг статистик агуулагддаг.

Сар бүрийн 16–18-нд Монголбанк нь Статистик бюллетенийг цахим хуудаснаа байршуулдаг.

Монголбанкны статистикийн сарын бюллетень

Сарын бюллетень
Монголбанк сарын статистикийн бюллетень



Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ХУДАЛДААНЫ ТОЙМ

stat.mongolbank.mn -> **Гадаад сектор** -> **Гадаад худалдааны тойм**

Монголбанк нь энэхүү тоймыг Гаалийн ерөнхий газрын "Гадаад

худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулдаг.

Монголбанк нь сар бүрийн 20-нд Гадаад худалдааны тоймыг цахим хуудсандаа байршуулдаг.

Гадаад худалдааны гүйцэтгэл (сая ам.доллар)

Төрөл	Эхний 3 сар			Өөрчлөлт	
	2022	2023	2024	2024/2023	
				Дүн	Хувь
Эргэлт	**3,633**	**5,704**	**6,073**	**369**	**6%**
Экспорт	1,942	3,764	3,659	-105	-3%
Импорт	1,691	1,940	2,414	475	24%
Тэнцэл	**251**	**1,824**	**1,245**	**-580**	

Эх сурвалж: Монголбанк

ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

stat.mongolbank.mn -> **Гадаад сектор** -> **Гадаад секторын тойм**

Гадаад секторын тойм нь төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өрийн улирлын эцсийн гүйцэтгэл гарсны дараа Монголбанкнаас зарлаж буй гадаад секторын статистикийг тоймлон, тус секторын тойм мэдээ, голлох өөрчлөлт зэргийг товч байдлаар олон нийтэд хүргэхэд чиглэсэн тайлан юм.

Улирал бүрийн дараагийн хоёр дахь сарын сүүлийн өдрөөс өмнө Монголбанк нь Гадаад секторын тоймыг цахим хуудаснаа байршуулдаг.

Гадаад секторын тойм

МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ 1

1. Төлбөрийн тэнцэл

2023 оны 3 дугаар улиралд урсгал ба хөрөнгийн данс 111 сая ам.долларын ашигтай, санхүүгийн данс 246 сая ам.долларын ашигтай, төлбөрийн тэнцэл 318 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өнгөрсөн оны мөн үеэтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны ашиг 489 сая ам.долларoор, санхүүгийн дансны ашиг 266 сая ам.долларoор тус тус өссөн үзүүлэлттэй байна (Зураг 1).

Зураг 1. Төлбөрийн тэнцэл, сая ам.доллар

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон[1] барааны худалдааны эргэлт 2023 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 16%-иар өсөж 6,139 сая ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 956 сая ам.долларын ашигтай гарсан (Зураг 2).

Зураг 2. Барааны худалдаа, сая ам.доллар

Үйлчилгээний худалдаа

Үйлчилгээний данс 2023 оны 3 дугаар улиралд 529 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 21%-иар буюу 140 сая ам.долларoор буурсан дүнтэй байна (Зураг 3).

Зураг 3. Үйлчилгээний худалдаа, сая ам.доллар

Эх сурвалж: Монголбанк

СЭДЭВ

09

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ БА МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Санхүүгийн тогтвортой байдлын талаар олон тодорхойлолт байдаг. Тэдний ихэнх нь санхүүгийн салбар нь* аливаа шокийг даван туулах, санхүүгийн тэнцвэргүй байдлаас гарах чадвартай байх тухай байдаг. Санхүүгийн тогтвортой байдал хангагдсанаар бодит эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц санхүүгийн зуучлалын ноцтой тасалдал үүсэх магадлалыг бууруулна[1]. Тогтвортой санхүүгийн систем нь нөөцийг үр ашигтай хуваарилах, санхүүгийн эрсдэлийг үнэлж, удирдах, ажлын байр нэмэгдүүлэх боломж олгохоос гадна мөнгөний тогтвортой байдал, эсвэл ажил эрхлэлтийн түвшинд нөлөөлөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн хөдөлгөөнийг хязгаарлах ач холбогдолтой.

Томоохон хэмжээний санхүүгийн тогтворгүй байдал нь аль нэг банкнаас харилцагчид нь мөнгөө нэг дор татаж, төлбөрийн чадваргүй болгох, гипер-инфляц үүсэх, хөрөнгийн зах зээлд хямрал үүсэх зэргээр илэрдэг нь санхүү, эдийн засгийн тогтолцоонд итгэх итгэлийг эрс алдагдуулж, улмаар урт хугацааны сөрөг үр дагаварт хүргэх аюултай байдаг.

Санхүүгийн тогтвортой байдлын хүрээ



1 * Санхүүгийн систем нь санхүүгийн зуучлагч, зах зээл, дэд бүтэц зэргээс бүрдэнэ. Дэлхийн банк

Иймээс үр ашигтай, тогтвортой санхүүгийн систем нь бодит үйлдвэрлэлийн өсөлт болон эдийн засгийн нөөцийн үр дүнтэй хуваарилалтыг дэмжиж, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг үнэн зөв, ил тод болгон, хуримтлал, хөрөнгө оруулалт бий болгох замаар баялгийг бүтээх, хөгжлийг бий болгох, бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа тогтвортой явуулах нөхцөлийг бүрдүүлэх, мөнгө, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн байдаг. Мөн урьдчилан тооцоолоогүй санхүү, эдийн засгийн хямрал болон тогтвортой бус байдал үүсэхэд энэхүү таагүй нөхцөл байдлыг сарниулж, эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг даван туулах чадварыг олгодог.

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Банкны салбарын найдвартай тасралтгүй ажиллагааг хангахын тулд Монголбанкнаас банканд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдүүлж хяналт тавьдаг. Санхүүгийн салбарын болзошгүй эрсдэлээс сэргийлэхийн тулд тухайн нөхцөлд нийцсэн мөчлөг сөрсөн* макро эдийн засгийн цогц бодлогыг явуулах нь илүү үр дүнтэй юм. Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, төсвийн болон мөнгөний бодлогын арга хэрэгслийг мөчлөг сөрсөн байдлаар ашиглах нь мөчлөгийн далайцыг багасгах, уналтын үеийг хамгийн бага хохиролтойгоор даван туулахад тусалдаг.

Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

№	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд (2024 онд)
1.	Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа, түүнийг хамгаалах нөөц
	· Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа => 9% · Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа => 12% · Хөшүүргийн харьцаа=> 5% · Нөөц интервал:

[2] * Эдийн засгийн мөчлөгийг сөрсөн бодлого, арга хэмжээ нь эдийн засгийн аливаа салбарт эрсдэл хуримтлагдаж, улмаар цаашид хямралд хүргэхээс урьдчилан сэргийлэх зорилготой.

	o Суурь хэсэг 2% o Тусгай хэсэг нь тогтмол болон хувьсах бүрэлдэхүүнтэй. Тогтмол хэсэг нь 1 нэгж хувь байх бол хувьсах хэсгийг дараах хүснэгтийн дагуу тооцно (зөвхөн системд нөлөө бүхий банканд):				
	Үзүүлэлтүүд	Тайлбар	Тусгай хэсгийн шаардлага		
	Системийн нийт активд эзлэх хувь	Өмнөх жилийн эцсийн үзүүлэлтээр	15%-аас бага бол 0%	15%-аас бол +0.5%	их
	Нийт банк хоорондын дамжуулсан гүйлгээний тоонд эзлэх хувь	Өмнөх жилд хийгдсэн нийт тоогоор	10%-аас бага бол 0%	10%-аас бол +0.25%	их
	Нийт иргэдийн зээлд эзлэх хувь, нийт байгууллагын зээлд эзлэх хувь хоёрын хамгийн их	Өмнөх жилийн эцсийн үзүүлэлтээр	10%-аас бага бол 0%	10%-аас бол +0.25%	их
2.	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа · Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа >= 25%				
3.	Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа Нэгж валютын нээлттэй позиц <= өөрийн хөрөнгийн 15% Нийт валютын нээлттэй позиц <= өөрийн хөрөнгийн 30%				
4.	Төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа · Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад активын нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь <= 20% · Банкны холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив: o Нийлбэр нь өөрийн хөрөнгөд эзлэх хувь <= 20% o Нэг этгээдийн хувьд өөрийн хөрөнгөд эзлэх хувь <= 5% · Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын нийлбэр <= өөрийн хөрөнгийн 300% · Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийн нийлбэр <= Нийт активын 8% Хамгийн том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын нийлбэр <= Нийт активын 25%				

Эх сурвалж: Монголбанк

*Тайлбар: * – Сүүлийн 6 сарын туршид банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг бүрдүүлж байгаа банканд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар нэмэлт өөрийн хөрөнгийн хэмжээг тогтооно.*

МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО

Макро зохистой бодлогын стратеги

2018 оны 1 дүгээр сард Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдаж, Монголбанк макро зохистой бодлого

хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнтэй холбогдуулан зарим улс орны сайн туршлага, олон улсын байгууллагын зөвлөмжид тулгуурлан макро зохистой бодлогын арга хэрэгслүүд, институцийн зохион байгуулалт, бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд баримтлах ерөнхий зарчмыг тодорхойлон хэрэгжүүлж байна.

Макро зохистой бодлогын үүсэл, хөгжил

Урт хугацаанд тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийн чухал суурь нөхцөл нь макро эдийн засгийн тогтвортой байдал юм. Макро эдийн засгийн тогтвортой байдал гэдэгт эдийн засгийн дотоод тэнцвэр буюу бүрэн ажил эрхлэлттэй үеийн үнийн тогтвортой байдал, гадаад тэнцвэр буюу төлбөрийн урсгал тэнцлийн урт хугацааны тогтвортой байдал гэсэн хоёр үндсэн нөхцөл зэрэг хангагдах төлөвийг түгээмэл авч үздэг.

Макро зохистой бодлого гэж юу вэ?

Макро зохистой бодлого гэдэг нь санхүүгийн нийт системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлогын цогц арга хэмжээ юм. Энэхүү бодлогын үндсэн зорилт нь хуримтлагдаж буй системийн эрсдэлийг хязгаарлах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, системийн эрсдэл нэгэнт үүсэх нь тодорхой болсон тохиолдолд түүнд бэлтгэлтэй байх болон тэрхүү эрсдэлийг алдагдал багатайгаар туулах явдал юм.

Макро зохистой бодлогын арга хэрэгслүүд

Макро зохистой бодлогын гол хэрэгсэл нь системийн эрсдэлийг удирдах зорилго бүхий зохистой харьцааны үзүүлэлтүүд байдаг. Тухайн улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал болон ирээдүйд тулгарч болзошгүй эрсдэлээс хамааран улс орнууд макро зохистой бодлогын хэрэгсэл (МЗБХ)-ээс сонголтоо хийн хэрэгжүүлдэг. Макро зохистой бодлогын үндсэн хэрэгслүүдийг эдийн засгийн үзүүлэлттэй уялдуулан доор харууллаа.

Макро зохистой зарим үзүүлэлт ба МЗБХ-үүд

Бодлогын хэрэгслүүд	Боломжит үзүүлэлтүүд
Өөрийн хөрөнгөд суурилсан хэрэгслүүд	
Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц	Зээлийн мөчлөг
Динамик эрсдэлийн сан	Банк тус бүрийн зээлийн өсөлт, эрсдэлийн сан
Өөрийн хөрөнгийн шаардлага (салбараар)	· Зээлийн өрийн үлдэгдэл, шинээр олгосон зээл салбараар (банк хооронд санхүүгийн бус хувийн салбар, өрх гэх мэт); · Салбарын төвлөрлийн үзүүлэлтүүд; · Үл хөдлөх хөрөнгийн үнэ (хөрөнгө оруулалтын болон орон сууцны, шинэ болон хуучин байдал); · Орон сууцны үнэ, түрээсийн харьцаа.
Хөрвөх чадварт суурилсан хэрэгслүүд	
Мөчлөг сөрсөн хөрвөх чадварын шаардлага	· Богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа; · Тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR); · Хөрвөх чадвар бүхий актив, богино хугацаат өр төлбөрийн харьцаа; · Зээл-хадгаламжийн харьцаа; · Хүүний зөрүү.
Зах зээлийн зөрүү ба хямдруулалт	· Зөрүү ба хямдруулалт; · Авах-зарах үнийн зөрүү; · Хөрвөх чадварын үнэ; · Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хөшүүрэг.
Активт нөлөөлөх хэрэгслүүд	
· Зээл-үнэлгээний харьцаа; · Өр-орлогын харьцаа (ӨОХ)	Үл хөдлөх хөрөнгийн үнэ (хөрөнгө оруулалтын болон сууцны, шинэ болон хуучин); Орон сууцны үнэ, түрээсийн харьцаа; Орон сууцны зээлийн өсөлт; Өрхийн эмзэг байдлыг илэрхийлэгч үзүүлэлтүүд.

Эх сурвалж: Committee on the Global Financial System (2012)

Дэлхий нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас өмнөх хугацаанд уламжлалт мөнгөний бодлого нь өөрийн зорилтод хүрч, өсөлтийг дэмжихийн сацуу үнийн тогтвортой байдлыг бий болгож байсан ч бодлогын хүрээнд орхигдсон зүйл нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах явдал байлаа. Тухайлбал, макро эдийн засгийн тогтвортой байдал удаан үргэлжилсэн нь санхүүгийн зах

зээлд оролцогчдын хувьд системийн эрсдэлийг дутуу үнэлэх, ашгаа нэмэгдүүлэхийн тулд илүү эрсдэлд дуртай болох хандлагыг бий болгосон байна. Улмаар санхүүгийн салбар дахь хяналт, шалгалт, зохицуулалтын асуудлууд, мэдээллийн хүртээмжгүй байдал зэрэг нь 2008 оны олон улсын санхүүгийн хямралыг нөхцөлдүүлжээ. Ийнхүү макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдлыг хангах, түүнд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал болохыг сануулсан ажээ.

Уламжлалт мөнгөний бодлогын нэг дутагдалтай тал нь санхүүгийн салбар дахь тэнцвэргүй байдал (imbalances)-ыг харгалзаж үздэггүй юм. Мөнгөний бодлогын шийдвэр гаргалтад гол үндэслэл болдог инфляц болон эдийн засгийн идэвхжил, мөчлөгийн төсөөлөл нь мөнгөний бодлогын шилжих механизм, эдийн засгийн төлөв байдал, зарим чухал экзоген хувьсагчдын таамаглалд үндэслэсэн байдаг. Харин санхүү, зээлийн мөчлөг, хөрөнгийн үнийн өсөлт, санхүүгийн салбар дахь тэнцвэргүй байдал, болзошгүй хөрөнгийн үнийн хөөсрөлт зэрэг санхүүгийн салбар дахь хүндрэлийг илтгэх үзүүлэлтүүд нь инфляц болон эдийн засгийн идэвхжилд хэрхэн нөлөөлөх байдлаас нь харьцангуй хязгаарлагдмал хүрээнд авч үздэг. Санхүүгийн салбар дахь дээр дурдсан асуудлыг шийдэхэд дан ганц уламжлалт мөнгөний бодлого хангалтгүй бөгөөд түүнтэй харилцан уялдаа бүхий системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн оновчтой микро болон макро зохистой бодлого шаардлагатай юм.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах гэдэгт хямрал болон санхүүгийн тогтвортой байдлыг урьдчилан таах, дохиолох гэхээс илүү санхүүгийн салбарын үйл ажиллагаа эрүүл, зохистой хэм хэмжээнд явагдаж буй эсэхэд чиглэсэн байнгын хяналт, шалгалт, тогтворжуулалтын болон системийн эрсдэлийг бууруулах идэвхтэй бодлогыг тохиромжтой институцийн хүрээнд бусад бодлогын хэрэгсэлтэй харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэх ойлголт багтана.

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа аль институцийн бодлогын зорилт байх нь улс орны институцийн уламжлалт загвар, хууль, эрх зүйн орчин зэргээс хамаарах ба Төв банканд суурилсан

байх нь түгээмэл байдаг. Гэхдээ улс орны санхүүгийн тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа зөвхөн төв банкаар хязгаарлагдахгүй ба Сангийн яам, санхүүгийн зохицуулалт хийх эрх бүхий этгээдийн үүрэг, оролцоо чухал юм. Тиймээс ч олон улсад эдгээр байгууллагын төлөөлөл хамтарч санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг бүтцийг бий болгож, ажиллах нь түгээмэл болжээ.

Монгол Улсад Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийг анх 2007 онд байгуулсан. СТБЗ-ийн үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор тогтолцооны шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах явдал юм. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирал багтдаг. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит (улирал бүр) болон ээлжит бус хуралдаан бөгөөд жил бүр санхүүгийн тогтвортой байдлын тайланг гаргаж, иргэд, олон нийтэд танилцуулдаг.

СЭДЭВ

10

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Төлбөр гүйцэтгэгчээс төлбөр хүлээн авагчид мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх, түүнтэй холбогдсон хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээ, техник технологи, дэд бүтэц, программ хангамж, төлбөрийн хэрэгсэл бүхий цогц бүтцийг төлбөрийн систем гэнэ.

ЕРӨНХИЙ БҮТЭЦ

Монгол Улсын төлбөрийн систем нь оролцогч хоорондын их дүнтэй гүйлгээний "Банксүлжээ" (RTGS) төлбөрийн систем, бага дүнтэй гүйлгээний "Автомат клиринг хас" (ACH+) төлбөрийн систем болон төлбөрийн картын систем гэсэн гурван систем (Зураг 11.1)-ээс бүрддэг.

"Банксүлжээ" системээр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс хойш 5 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ дамжиж байгаа бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулдаг.

"Автомат клиринг хас" (ACH+) системээр 5 сая төгрөг, түүнээс доош дүнтэй гүйлгээ дамждаг бөгөөд тус систем нь гүйлгээг бодит цагийн горимд, 24/7 зарчмаар тасралтгүй дамжуулах, эсхүл багц болгож тодорхой давтамжийн дагуу дамжуулах сонголтыг хэрэглэгчид олгодог.

Төлбөрийн картын систем нь Монгол Улсад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага хоорондын картын гүйлгээг дамжуулж, клиринг хийдэг бөгөөд ACH+ системтэй адил зарчмаар үр дүнг цэвэршүүлэн тооцож, дараагийн ажлын өдөр "Банксүлжээ" системд дамжуулж, оролцогчдын дансанд тусгадаг.

Төлбөрийн системийн хууль, эрх зүйн тогтолцоо

Монгол Улсын төлбөрийн системийн эрх зүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд "Үндэсний төлбөрийн системийн тухай хууль"-ийг шинээр боловсруулан, УИХ-аар батлуулж, 2018 оны 1 сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах үүрэг хариуцлагыг Монголбанканд олгож, эрх зүйн хувьд баталгаажуулсан.

Төлбөрийн систем дэх Монголбанкны үүрэг, оролцоо

Монголбанк нь төлбөрийн системийн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэдэг ба үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлохын зэрэгцээ хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай өөрчлөлтийг хийх замаар төлбөр тооцооны системүүдийн найдвартай, тасралтгүй, ажиллагаа, үр ашигтай байдлыг хангуулснаар мөнгөн тэмдэгтэд итгэх олон нийтийн итгэл, санхүүгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлдэг.

Монголбанкнаас төлбөрийн системийн найдвартай ажиллагааг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор төлбөр

тооцоонд шинээр нэвтэрч буй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг судлан дүгнэлт гаргаж, системийн оролцогч банканд холбогдох зөвшөөрлийг олгож, төлбөр тооцоог бодит цагийн горимоор, тасралтгүй дамжуулж байгаа эсэх, холбогдох журам, гэрээг мөрдөж байгаа эсэх, түүнчлэн өмнө шалгалтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн эсэхэд хяналт тавьж, тогтмол шалгалт хийж байна.

Шимтгэл, цагийн хуваарь

Төлбөр тооцооны системүүдийн ажиллах цагийн хуваарь, дамжуулсан гүйлгээ тутмаас Монголбанкны авах шимтгэлийг дараах хүснэгтэд харууллаа.

Төлбөр тооцооны системийн ажиллах цагийн хуваарь, дамжуулсан гүйлгээний шимтгэл

Төрөл	Ажлын цаг	Шимтгэл
Бага дүнтэй гүйлгээ	24 цагаар	Гүйлгээ тутамд ₮110
Их дүнтэй гүйлгээ	9:10 – 16:30 цагт	Гүйлгээ тутамд ₮400
Төлбөрийн карт ашиглан бэлэн мөнгө авах үйлчилгээ	24 цагаар	Гүйлгээ тутамд ₮50
Төлбөрийн картын үлдэгдэл шалгах гүйлгээ	24 цагаар	Гүйлгээ тутамд ₮10

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар "Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл"-ийг шинэчлэн баталж, мөрддөг. Энэ үйлчилгээний шимтгэлийн нөхцөлд зөвхөн төлбөрийн системийн оролцогч банкнаас Монголбанкны авах шимтгэлийг тусгасан байдаг ба харилцагчаас авах шимтгэлийг "Банкны тухай" хуульд заасны дагуу төлбөр тооцооны үйлчилгээний үзүүлж байгаа банк нь өөрөө тогтоодог.

СЭДЭВ

11

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

Ногоон эдийн засаг гэдэг нь байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийн загвар юм. байгаль орчны нөөцийг хэмнэлттэй ашиглах, бохирдлыг багасгах, хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, нийгмийн тэгш байдлыг хангах зэрэгт гол анхаарлаа хандуулдаг. Ногоон эдийн засгийн гол зорилго нь өнөөгийн болон ирээдүйн хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах бөгөөд энэхүү зорилгод хүрэхийн тулд байгаль орчинд ээлтэй, тогтвортой үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулахад чиглэнэ. Өөрөөр хэлбэл уламжлалт эдийн засгийн загваруудын байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх нөлөөг багасгах зорилготой юм.

Ногоон эдийн засгийн гол зарчмууд:

1. Тогтвортой байдлыг хангах: байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй, экосистемийг хамгаалах дадал зуршлыг дэмжих;
2. Бохирдлыг багасгах: Агаар, ус, хөрсний бохирдлыг багасгах арга хэмжээг дэмжих.
3. Хүлэмжийн хийг бууруулах: Хүлэмжийн хий ялгаруулалтыг багасгах, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, эрчим хүчний хэмнэлтэд анхаарах.
4. Нөөцийн үр ашиг: Ус, ашигт малтмал, ой мод зэрэг байгалийн нөөцийг илүү үр ашигтай, хаягдал багатай ашиглахыг онцлох.
5. Нийгмийн хүртээмж: Ногоон ажлын байрыг нэмэгдүүлж, хүний сайн сайхан байдлыг сайжруулахын зэрэгцээ ядуурал, тэгш бус байдлыг бууруулахад чиглэдэг.

Ногоон эдийн засагт шилжих нь олон улсын уур амьсгалын зорилтууд, тухайлбал Парисын гэрээ болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нягт холбоотой байдаг.

Ногоон эдийн засгийг дэмжих арга:

- Бодлого, зохицуулалт: Засгийн газар нь ногоон санхүүжилт, татварын хөнгөлөлт зэрэг арга замаар дэмжлэг үзүүлэх боломжтой.
- Ногоон санхүүжилт: Ногоон төслүүдэд хөрөнгө оруулах, ногоон бонд гаргах зэрэг санхүүгийн шийдлүүдийг хэрэглэх.
- Сургалт ба боловсрол: Байгаль орчны боловсрол, ногоон санхүүгийн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх.

Ногоон буюу тогтвортой санхүүжилт

Тогтвортой санхүүжилт нь санхүүгийн үйлчилгээ, хөрөнгө оруулалтыг байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) шалгууруудтай уялдуулан явуулахыг хэлнэ. Энэ нь ногоон эдийн засаг руу шилжих үйл явцыг санхүүжүүлэх гол арга зам бөгөөд нийгэм, байгаль орчинд ээлтэй төслүүдийг дэмжихэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг идэвхжүүлдэг.

Өөрөөр хэлбэл, ямар нэгэн санхүүгийн шийдвэр гаргахдаа зөвхөн ашиг орлого биш, харин тухайн төсөл нь байгаль орчин, нийгэмд сөрөг нөлөөтэй эсэхийг нь давхар харгалзан үзэж хөрөнгө оруулалт хийхэд анхаарна гэсэн үг.

Тогтвортой санхүүжилтийн гол бүрэлдэхүүн:

1. Ногоон бонд: Байгаль орчны эерэг нөлөөтэй төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргадаг бонд.
2. ESG хөрөнгө оруулалт: Компаниудын байгаль орчин, нийгэм, засаглалын үзүүлэлтүүдийг ашиглаж, санхүүгийн өгөөжтэй хамт үнэлдэг хөрөнгө оруулалт.
3. Нөлөөллийн хөрөнгө оруулалт: Нийгэм, байгаль орчинд эерэг үр нөлөө үзүүлэх зорилго бүхий хөрөнгө оруулалт.
4. Тогтвортой банк: Банкны зээл, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн зарчмыг нэвтрүүлдэг.

Тогтвортой санхүүжилтийн зарчмыг хэрэгжүүлэх нь санхүүгийн байгууллагууд, тэдний харилцагчийн эрсдэлийг бууруулдаг бөгөөд ногоон эдийн засгийн өсөлтийг бий болгох, нийгмийн сайн сайхан байдал, байгаль орчныг хамгаалах, сайн засаглалыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Тогтвортой санхүүжилт Монгол улсад

Монголын банкны холбоо болон арилжааны банкууд ногоон ирээдүйн төлөө байгаль орчин нийгмийн асуудлыг чухалчлан "Тогтвортой санхүүжилт" (ToC) хөтөлбөрийг 2013 онд санаачилснаар Монгол Улсын тогтвортой санхүүжилтийн түүх эхэлжээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд банкууд тогтвортой санхүүжилтийн 8 зарчмыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн байна. Ингэснээр банк зээл олгохдоо тухайн төслийн зөвхөн ашиг, зардлыг биш, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг давхар үнэлж, өөрөөс болон зээлдэгчээс нийгмийн хариуцлагатай байхыг шаарддаг болжээ.

Монголын тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам зэрэг төрийн бодлогын болон санхүүгийн салбарын зохицуулах байгууллагууд бодлогоор идэвхтэй дэмжиж, хамтран ажиллаж байгаа юм.

Үндэсний ногоон таксономи

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2019 онд "Үндэсний ногоон таксономи"-г батлан гаргаснаар Монгол Улсад ногоон зээл гэж юуг хэлэх, ангилал нь ямар байх шалгуур батлагдсанаар гадаад, дотоодын зах зээлээс ногоон санхүүжилт татах, ногоон зээл олгох, ногоон зээлийг бүртгэх, хянах зэрэг ногоон төслүүдийг хөгжүүлэх, банк, санхүүгийн байгууллагууд болон бизнес, иргэдийг чадавхжуулахад бодитой суурь нөхцөл бүрэлдэж байгаа юм. Улмаар арилжааны банкууд 2020 оны 1 дүгээр улирлаас эхлэн ногоон зээлийн тайланг Монголбанкинд улирал бүр тайлагнадаг болжээ.

Банк, санхүүгийн байгууллагууд нь бизнесийн үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэм засаглалын хувьд тогтвортой байдлыг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй байхыг зорьж ногоон зээлийн бүтээгдэхүүнийг олон төрлөөр зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. Ногоон зээлийн төрлөөс дурдвал:

- Эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан халаагуур;
- Гэрийн сайжруулсан зуух;
- Гэр, байшингийн дулаалгын материал;
- Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр;
- Хувийн орон сууцыг инженерийн шугам сүлжээнд холбох;
- Хийн халаалт;
- Гэр хорооллын нүхэн жорлон;
- Бага оврын цэвэрлэх байгууламж;
- Цахилгаан тээврийн хэрэгсэл (Цахилгаан машин, цахилгаан мотоцикл, цахилгаан сүүтэй, бүх төрлийн унадаг дугуй);
- Ногоон барилга (амины орон сууц) гэх мэт олон нэр төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг жилийн жилийн 2–3% хүүтэйгээр, 30 хүртэлх сарын хугацаатайгаар 5–50 сая хүртэл төгрөгийн ногоон зээлийг харилцагчдадаа санал болгосоор байна.

Тогтвортой санхүүжилтийн үндэсний зураг

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2022 онд "Тогтвортой санхүүгийн үндэсний зураг" бодлогын баримт бичгийг баталсан байна. Энэхүү баримт бичиг нь тогтвортой санхүүжилт, ногоон санхүүжилтийн хөгжлийг санхүүгийн салбарын хөгжилтэй уялдуулан, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, шаардлагатай сургалт, хамтын ажиллагаа зэрэг тогтвортой, ногоон санхүүг хөгжүүлэх зураглалыг тодруулсан иж бүрэн баримт бичиг юм.

Сүүлийн жилүүдэд тогтвортой, ногоон санхүүжилтийн тухай ойлголт эрчимтэй түгэн дэлгэрч байгаа бөгөөд бодитой эрэлт хэрэгцээ нь банк, санхүү, бизнесийн салбар, иргэдийн дунд өсөн нэмэгдэж байна. Тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж эхлээд удаагүй боловч Монгол Улс тогтвортой санхүүжилтийг "ахисан түвшинд" хэрэгжүүлж буй улс орнуудын нэгэнд тооцогддог болжээ. Гэхдээ Монголд тогтвортой санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлж, зах зээлд илүү олон төрлийн ногоон санхүүгийн бүтээгдэхүүн бий болгох шаардлага байсаар байна.

НОМ ЗҮЙ

Монголбанк. (2013). Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан. Дугаар 1,

Монголбанк. (2014). Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан. Дугаар 3, Монголбанк. (2023). Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан. Дугаар 17, Монголбанк. (2024). Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан. Дугаар 18, Монголбанк. (2018). Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах дүрэм.

BIS. (2012). Characterising the financial cycle: Don't lose sight of medium term!.

BIS Working Papers No 380.

IMF. (2012). Financial stability reports: What are they good for?. WP/12/1, Washington.

IMF. (2011). Macroprudential policy: An organizing framework. Washington.

IMF. (2011).Macroprudential policy: What instruments and how to use them?. WP/11/238, Washington.

IMF. (2014). Annual Report on Exchange Arrangements and Exchange Restrictions. Washington.

IMF. (2023). Fiscal Policy and Monetary Policy Interaction: Navigating Challenges. International Monetary Fund Working Paper WP/23/45.

Mishkin, F. (2021). The economics of money, banking, and financial markets. 13th edition, Pearson Education.

Obstfeld, M. (2017.) Two Trilemmas for Monetary Policy. Bank Negara Malaysia Conference on "Monetary Policy 2.0?"

Robert Shiller (2011). Banks, Lecture 13, Yale University, online.yale.edu

Romer, D. (2022.) Advanced Macroeconomics. 5th ed. McGraw-Hill Education.

World Bank. (2012). Benchmarking financial systems around the world. Policy Research Working Paper, WPS6175.